



ЭРЧИМ ХҮЧНИЙ
ЯАМ



ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ БАРИХ ТӨСӨЛ

**ХОВД, БАЯН-ӨЛГИЙ, УВС АЙМГИЙН НУТАГТ ХЭРЭГЖИХ
“ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ БАРИХ”
ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2024 он

АГУУЛГА

ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	3
1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	5
1.1 Нуур үүсэхээс өмнө төслийн талбай дахь ой модны нарийвчилсан судалгаа	6
1.1.1 Дүгнэлт	7
1.1.2 Зөвлөмж	8
1.2 Хөрсний микробиологийн судалгаа	9
1.2.1 Дүгнэлт	15
1.2.2 Зөвлөмж	15
1.3 Төслийн талбай дахь сээр нуруутан амьтдын судалгаа	16
1.3.1 Судалгааны арга зүй	16
1.3.2 Хөхтөн амьтдын зүйлийн бүрэлдэхүүн	16
1.3.3 Шижигтийн хавцал орчмын шувуудын зүйлийн бүрэлдэхүүн, орших хэлбэр	20
1.3.4 Шувуудын хээрийн судалгааны үр дүн	21
1.3.5 Дүгнэлт	22
2 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ	25
2.1 Соёлын биет бус өв буюу Угсаатан зүйн авран хамгаалах тандалт судалгаа	26
2.2 Төслийн нуур үүсэх талбай дахь 60 иргэний булш бунханыг нүүлгэн шилжүүлэх	29
3 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭ	31
4 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	32
4.1 Агаарын чанар	32
4.1.1 Орчны дуу шуугиан	34
4.1.2 Дүгнэлт	35
4.2 Усан орчин	35
4.2.1 Дүгнэлт	36
4.3 Хөрсөн бүрхэвч	37
4.3.1 Дүгнэлт	37
4.4 Ургамлан нөмрөг	38
4.4.1 Дүгнэлт	40
4.5 Амьтны аймаг	41
4.5.1 Дүгнэлт	42
5 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ	43
6 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ	44

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	5
Хүснэгт 2. Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын Хавцлаас дээш үүсэх нуур орчимд тархсан хөхтөн амьтдын зүйлийн бүрэлдэхүүн, тэдгээрийн ховордлын зэрэглэл	16
Хүснэгт 3. Ховд голын УЦС-ын далангаас дээш үүсэх нуурын нөлөөнд өртөх шөнийн идэвхтэй жижиг хөхтөн амьтдын зүйлийн тоо толгойн үзүүлэлт (нийт 800 занга/хоногт ноогдох тоогоор)	18
Хүснэгт 4. Эрдэнэбүрэнгийн УЦС-ын далангаас дээш орших татмын нугын биотопд тохиолдох өдрийн идэвхтэй жижиг хөхтөн амьтдын зүйлийн тоо толгойн үзүүлэлт	20
Хүснэгт 5. Төслийн талбай дахь шувуудын амьдрах орчин, тоо толгойн байдал	21
Хүснэгт 6. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	25
Хүснэгт 7. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ	31
Хүснэгт 8. ОХШХөтөлбөр	32
Хүснэгт 9. Агаарын чанарын мониторинг судалгаанд ашиглагдсан багаж төхөөрөмж	32
Хүснэгт 10. Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	43

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Ой модны харагдах байдал	6
Зураг 2. Дээж авсан газруудын байршил	9
Зураг 3. Усан цахилгаан станци барих газрын усан сан үүсэх талбай, нийт 10000 га	10
Зураг 4. Орон зайн тархалт (Нянгийн тоо)	11
Зураг 5. Орон зайн тархалт (Анаэроб)	12
Зураг 6. Орон зайн тархалт (Гэдэсний савханцар)	13
Зураг 7. Орон зайн тархалт (Нянгийн тоо)	14
Зураг 8. Эрдэнэбүрэнгийн Усан Цахилгаан Станцын үндсэн талбайд хийсэн угсаатны зүйн хээрийн судалгааны үеэр бүртгэгдсэн соёлын орон зайт бүсүүдийн байршил	28
Зураг 9. Ариутгал хийж буй байдал	29
Зураг 10. Байршуулсан байдал	30
Зураг 11. Агаарын чанарын мониторингийн цэгүүд	33
Зураг 12. Дуу шуугианы хэмжилтийн цэгүүд	34
Зураг 13. Дуу шуугианы хэмжилтийн цэгүүд	35
Зураг 14. Усны дээж авсан цэгийн байршил	36
Зураг 15. Төслийн талбай орчмын хөрсний тархалт, зүсэлт хийж дээж авсан цэгүүдийн байршил	37
Зураг 16. Ургамал газарзүйн мужлалт	39
Зураг 17. 2020-2024 оны ургамалжилтын зураг	40
Зураг 18. Усны шувууд	41
Зураг 19. Увс аймгийн БОАЖГазар	44
Зураг 20. Ховд аймгийн БОАЖГазар	45
Зураг 21. Баян-Өлгий аймгийн БОАЖГазар	45

ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

УЦС барих төслийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, ТЖБОМТ-ний биелэлтийг нөлөөллийн бүс дэх оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө, Нүүлгэн шилжүүлэх, нэг удаагийн нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөнд нийт 13,284.0 сая төгрөгийг төлөвлөсөн болно. Монгол улсын Эрчим хүчний сайдын 2024 оны 10 сарын 16-ны өдрийн А/223 тоот “Тушаал шинэчлэн батлах тухай” тушаалаар Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө, Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, Түр замын БОТБҮ, Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, Төслийн нөлөөлөлд хамаарах айл өрхийн иргэн бүрд олгох нөхөн төлбөрийн үндэслэл, үр нөлөөллийн судалгаа зэрэг ажлуудад 1,026.9 сая төгрөг, Нүүлгэн шилжүүлэх, нэг удаагийн нөхөн төлбөрт 12,257.4 сая төгрөг баталсаны дагуу биелэлтийн тайланг боловсруулав /тушаалыг хавсралтаар тусгав/.

Төслийн БНХАУ-ын ЭКСИМ банктай байгуулах “Тусгайлсан зээлийн хэлэлцээр” 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр баталгаажиж гэрээнд гарын үсэг зурагдсан учир 2024 оны БОМТ-нд тусгагдсан Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ; Орчны тохижилт, нөхөн сэргээлт; Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө; Хог хаягдлын менежментийн арга хэмжээнүүд хойшилж, 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг 2025 оны төлөвлөгөөнд тусгахаар боловсруулаад байна.

2024 онд төлөвлөсөн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Биелэлтийн тайлбар
Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Бүлэг 1-д тайлагнасан. Мөн БНХАУ-ын ЭКСИМ банктай байгуулах “Тусгайлсан зээлийн хэлэлцээр” 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр баталгаажсан учир төлөвлөсөн хугацаанд зарим төлөвлөгөөт ажлууд хийгдээгүй байна.
Орчны тохижилт, нөхөн сэргээлт	БНХАУ-ын ЭКСИМ банктай байгуулах “Тусгайлсан зээлийн хэлэлцээр” 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр баталгаажсан учир төлөвлөсөн хугацаанд ажлууд хэрэгжээгүй байна.
Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ	Бүлэг 2-д тайлагнасан.
Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ	Бүлэг 3-т тайлагнасан
Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	БНХАУ-ын ЭКСИМ банктай байгуулах “Тусгайлсан зээлийн хэлэлцээр” 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр баталгаажсан учир БОМТ-нд тусгагдсан осол эрсдэлээс сэргийлэх төлөвлөгөө хэрэгжээгүй байна.
Хог хаягдлын менежмент	БНХАУ-ын ЭКСИМ банктай байгуулах “Тусгайлсан зээлийн хэлэлцээр” 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр баталгаажсан учир төлөвлөсөн хугацаанд ажлууд хэрэгжээгүй байна.
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Бүлэг 4-д тайлагнасан.



Удирдлага зохион байгуулалт	Бүлэг 5-д тайлагнасан.
БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь	Бүлэг 6-д тайлагнасан.

1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Хүснэгт 1. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

ДД	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжилтийн тайлбар
1.	Бургасан шугуй, хайлаасны нөлөөлөлд өртөх	Нуур үүсэхээс өмнө төслийн талбай дахь ой модны нарийвчилсан судалгаа	Ой модны нарийвчилсан судалгааны ажлыг хийж гүйцэтгүүлэхээр 2024.10.08-ны өдөр “Үржил шимт сүрэг”-тай гэрээ байгуулан, тайланг 2024.12.03-ны өдөр хүлээн авсан. Тус тайлангаас бүлэг 1.1-д товч дурдав.
2.	Хөрсний микробиологийн бохирдлоос сэргийлэх	Хөрсний микробиологийн судалгаа хийх шинжилгээний зардал;	Хөрсний микробиологийн бохирдлоос сэргийлэх зорилгоор судалгааны ажлыг хийж гүйцэтгүүлэхээр 2024.10.10-ны өдөр “Хос нахиа” ХХК-тай гэрээ байгуулан, судалгааны ажлын тайланг 2024.12.02-ны өдөр хүлээн авсан. Тус тайлангаас бүлэг 1.2-д товч дурдав.
3.	Төслийн үйл ажиллагаанаас сээр нуруутан амьтдын амьдрах орчинд сөрөг нөлөө үзүүлэх	Амьтны аймгийн /Аргал зэрэг ховор амьтад/ нарийвчилсан судалгааг хийх, нутагшиж идээшсэн газруудад зайлшгүй ойртсон, дайрч өнгөрөх автозамын хэсэгт нүхэн гарц, ямарч саадгүйгээр нэвтрэх боломжийг судлах; Амьтдад хэрхэн нөлөөлж буйг маршрутын судалгаагаар тогтоох;	Амьтны аймгийн судалгаа хийх ажлын хүрээнд судалгааны ажлыг хийж гүйцэтгүүлэхээр 2024.10.10-ны өдөр “Монголын байгаль хамгаалагчдын холбоо” ТББ-тай гэрээ байгуулан, судалгааны тайланг 2024.11.29-ны өдөр хүлээн авсан. Тус тайлангаас бүлэг 1.3-д товч дурдав.

1.1 Нуур үүсэхээс өмнө төслийн талбай дахь ой модны нарийвчилсан судалгаа

Үндсэн хуульд зааснаар төрийн өмч, төрийн хамгаалалтад байдаг байгалийн баялгийн нэгэн чухал төрөл юм. Ой бол ургамал, амьтны өөрийгөө хамгаалах, харилцан үйлчлэх бүтэц юм. Ойн модод нь бичил цаг уур, хөрсний тусгай бүтэцтэй экосистемийг бий болгодог.

Ойгоор бүрхэгдсэн талбайд тухайн судалгааны үед ойтой болон улсын ойн санд шилжүүлсэн таримал ой, бут сөөгөөр битүү хучигдсан талбай орох ба ойгоор бүрхэгдээгүй ой талбайд одоогоор байхгүй боловч цаашид ой ургах нөхцөл бололцоотой газрууд (байгалийн аясаар ойжиж байгаа газар, тармаг модод, ойжуулсан талбай), урьд өмнө ойтой байсан талбай (шатсан ой, мод бэлтгэсэн талбай, ойн хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн талбай г.м.) тус тус хамрагддаг.

Ойн бус талбайд ойн сан доторх (цагаан энгэр, таг царам, хадлан, бэлчээр, гол, нуур, намаг, элс, мод үржүүлгийн талбай) зэрэг газрууд ордог.

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслийн талбайд хамрагдах Хар нуур-Ховд голын сав газар нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Алтай Соёны уулт Их мужийн Монгол Алтайн мужид хамаарна.

Ой мод нь байгаль орчин, эдийн засаг, нийгэм, соёлын олон талт өгөөжийг хүртээдэг нөхөн сэргээгддэг цогц экосистем юм. Нийгэмд хэрэгцээ шаардлага өөрчлөгдөхийн хирээр ойн үнэлгээ цаг хугацааг дагаад өөрчлөгдөж байдаг.



Зураг 1. Ой модны харагдах байдал

Шижигтийн хавцалын өмнөд ба хойд хэсгийн Ховд голын дагуух бургас, хус зонхилсон шугуйн одоогийн төлөв байдлыг тооцож үзэхэд нийтдээ 884 га талбайтай, 23,868 м³ нөөцтэй байна. Хавцалын өмнөд хэсгийн Ховд гол дагуух баруун зүүн эрэгт бургас, улиас, хус ойтой ба улиас нь 5-7 м, бургас 3-5 м, хус 4-7 м дундаж өндөртэй, 20-45 см дундаж диаметртэй байна.

Эдгээр ойн сан бүхий газар нь Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын усан санд хамрагдах ойгоор бүрхэгдсэн талбай 432 га, Увс аймгийн Өмнөговь сумын усан санд хамрагдах ойгоор бүрхэгдсэн талбай 452 га байна.

Нуур үүсэх талбай дахь ойн нөөц

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын нуур үүсэх талбайд Ховд гол дагуу ургасан байгалийн 884 га ойн талбай хамрагдах бөгөөд бургасан ойн 1 га-ийн нөөц нь 18 м³ бөгөөд

Баян-Өлгий аймгийн Баяннуур суманд хамрагдах 345.6 га бургасан ойн нөөц 6220.8 м³, Увс аймгийн Өмнөговь суманд хамрагдах 361.6 га бургасан ойн нөөц 6508.8 м³ байна.

Харин улиасан ойн 1 га-ийн нөөц 63 м³ бөгөөд Баян-Өлгий аймгийн Баяннуур суманд хамрагдах 86.4 га улиасан ойн нөөц 5443.2 м³, Увс аймгийн Өмнөговь суманд хамрагдах 90.4 га улиасан ойн нөөц 5695.2 м³ байна.

“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих” байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг “Ньюгидро проект” ХХК 2021 онд хийж гүйцэтгэсэн байна.

Уг БОННУ-гээр ойн экологи-эдийн засгийн үнэлгээг Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2020 оны 3-р сарын 16-ны өдрийн Ойн экологи-эдийн засгийн үнэлгээ батлах тухай А/176 тушаалын 1, 2-р хавсралтыг үндэслэн Ховд голын дагуу ургаж байгаа хамгаалалтын ойн сангийн модлог ургамлууд болох бургас, улиасан ойн талбайн экологи-эдийн засгийн үнэлгээг тооцсон байна. Шинэ аргачлалаар шууд бус үр ашгийн /ойн ус зохицуулах, хөрс хамгаалах, нүүрсхүчлийн хийг шингээх, нийгэм, амралт зугаалгын ач холбогдол зэрэг экологийн ач холбогдлын үнэлгээ/ хохирлыг нэмж тооцоолсон.

Нийт усан санд хамрагдах ойгоор бүрхэгдсэн талбай 884 га бөгөөд энэ талбайн 80 хувь буюу 707.2 га нь бургасан, 20 хувь буюу 176.8 га нь улиасан ой байна.

Насны анги бүрийн нөөцийг мөн ангийн насаар үржүүлсэн үржвэрүүдийн нийлбэрийг насны ангийн нөөцийн нийлбэрт хувааж дундаж насыг тогтоодог. Тус сумын байгалийн ойн дундаж нас улиасан ой 85 жил, бургасан ой 24 жил байна.

Нүүлгэн шилжүүлэх, тарьц суулгац бэлдэх

Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын усанд автаж байгаа 432 га талбай дээрх ЭЭЗҮ-ээр тооцсон хохирлыг Цамбагаравын БЦГ-ын нутаг дээр, Увс аймгийн Өмнөговь сумын усанд автаж байгаа 452 га талбай дээрх ЭЭЗҮ-ээр тооцсон хохирлыг Алтан Хөхүйн БНГ-ын нутаг дээр болон шинээр байгуулсан усан сангийн эргийн шугамын дагуу мод үржүүлгийн газар байгуулан жил бүрийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд туссан зардал түүнчлэн дүйцүүлэн хамгаалах зардлаас санхүүжүүлж бургас ба улиасны мөчрийг тайраадсаар нөхөн үржүүлэх замаар ойжуулах боломжтой юм.

- Төслийн талбайгаар явж ажиглалт хийхэд тэр хэсэгтээ байгалийн баян бүрд бүхий улиас, бургас, хус бүхий модлог ургамал, улаан харгана зэрэг ургасан байлаа. Дээрх мод бутнууд бол нилээн өндөр насжилтай холтос нь өмхөрч холцорсон, жил бүр малд их идэгдэг нь гаднаасаа ажиглагдав.
- Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын талын нутагт модлог ургамлаас хус, улиас дийлэнхи ургасан ба бургас хэсэг хэсгээр хааяа бүлэгээр ургасан, бутлаг ургамлаас улаан харгана ургадаг.
- Увс аймгийн Өмнөговь сумын талаас бургас зонхилон ургасан буюу бутлаг ургамлаас харгана, улиас бүлгээр хэсэгчлэн ургажээ.

1.1.1 Дүгнэлт

- Ихэвчлэн жигд өндөр настай мод учраас нүүлгэн шилжүүлэх шаардлагагүй, байгалийн аясаар сэргэн ургасан залуу зулзган мод байхгүй болно. Харин бургасны модлог мөчрийн тайраадас 500 000 орчмыг бэлтгэж хэрэгцээт газруудад өгч мод үржүүлгийн чиглэлээр үржүүлэх;
- Баян-Өлгий аймгийн Баяннуур сум, Увс аймгийн Өмнөговь сумдын албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэд бургасны модлог мөчрийн тайраадасаар хашаандаа болон салхины хамгаалалтын зорилгоор тарьж ургуулах боломжтой. Мөн элсний нүүдэл, цөлжилтийг

сааруулах зорилгоор ойн зурвас байгуулж болно. Бургасны модлог мөчрийн тайраадсыг бургас ихээр ургасан Увс аймгийн Өмнөговь сумын усанд автах тайбай дахь талбайгаас бэлдэх боломжтой. Уг мөчрийн тайраадсыг 12-03 сарын хооронд бэлтгэх боломжтой;

- Ой модыг үндэсээр нь чөлөөлөх;

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслийн нуур үүсэх талбайн усанд автах байгалийн ой болох улиас, бургас, хус мод болон бутлаг ургамал харгана насжилт өндөр учраас үндэстэй нь чөлөөлөөд өөр газар ургуулах боломж муу бөгөөд дээд талыг тайрч авбал хэдэн жилийн дараа уг модны үндэс ялзарч хөвж гарч ирэн далангийн боомтод их хэмжээгээр цугларан станцын хэвийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй юм.


Иймээс усанд автах нийт талбайд ургасан ойг техник, тоног төхөөрөмжийн хүчээр үндсээр нь газраас булга татан авч модыг ангилан иргэд, аж ахуйн нэгжүүдэд түлээ, түлш, бусад хэрэгцээнд ашиглуулах боломжтой.

1.1.2 Зөвлөмж

- Ой модны цэвэрлэх талбайн хэмжээ нийт 884 га бөгөөд бургас 12,729.6 м³, улиас 11,138.5 м³ орчим байна. Үүнийг задалбал:
- Баяннуур сум 432 га бөгөөд бургас 6,220.8 м³, Улиас 5,443.3 м³, Өмнөговь сумын Улиаст баг 452 га бөгөөд бургас 6,508.8 м³, улиас 5,695.2 м³ байна;
- Ойн цэвэрлэгээнээс гарсан модыг зохих эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ олгож тээвэрлэх, баруун аймгийн зах зээлд борлуулах;
- 1 га талбайг цэвэрлэхдээ зах зээлийн дунджаар тооцоход 500,000 төгрөг бөгөөд дээрх 884 га талбайг цэвэрлэхэд 442,000,000 /дөрвөн зуун дөчин хоёр сая/ төгрөг гарахаар байна. Хэрэв цэвэрлэгээ хийхэд төлөвлөсөн санхүүжилт бага байвал гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулан тухайн цэвэрлэгээнд гарсан ой модыг зах зээлд худалдан борлуулах замаар олох боломжтой;
- Ойн цэвэрлэгээ хийхдээ БОАЖС-ын 2020 оны А/684 дугаар тушаалаар баталсан “Ойд арчилгаа цэвэрлэгээ хийх журам, “Ойн Судалгаа Хөгжлийн Төв” УТҮГ-ын захирлын 2018 оны А/99 тоот тушаалын 1,2,3- р хавсралтаар баталсан “Ойд арчилгаа хийх технологиин заавар”, “Ойд цэвэрлэгээ хийх технологийн заавар” -уудыг мөрдөж ажиллах нь зүйтэй гэж үзэж байна;

1.2 Хөрсний микробиологийн судалгаа

Тухайн төслийн талбайн нь Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум, Увс аймгийн Өмнөговь сум, Баян-Өлгийн аймгийн Баяннуур сумын нутаг дэвсгэрт хэрэгжих бөгөөд Судалгааны ажлын талбайн Увс аймгийн Өмнөговь сумын 125 айл өрх, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын 145 айл өрхийн газруудад дээж авсан байна.



Зураг 2. Дээж авсан газруудын байршил

Судалгаа явуулсан газар нь Эрдэнэбүрэн усан цахилгаан станц төслийн нуур үүсэх талбайд байрлах айл, өрх, малын бууц, өвөлжөө бүхий Баян-Өлгийн аймгийн Баяннуур сум, Увс аймгийн Өмнөговь сумын нутаг дэвсгэр болно. Хөрсний өнгөн хөрсний нянгийн

бохирдолтыг тодорхойлох зорилгоор дээж авсан. Дээж авсан цэгийг нуур үүсэх талбай байрлаж буй айлуудыг сонгосон. Өрөмдлөгийн гүн 10 см байсан хөрсний дээж авсан. Нийтдээ 157 цэгээс дээж авч “НАРТ ШҮҮН КОНСАЛТИНГ” ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид задлан шинжлүүлж үр дүнд анализ хийсэн байна. Хээрийн судалгаагаар авсан бүх дээжнүүдэд хөрсний эрүүл ахуй нянгийн шинжилгээг хийлгэсэн.

Баян-Өлгий аймгийн Баяннуур ба Увс аймгийн Өмнөговь сумын зааг нутаг Ховд гол дээр Усан цахилгаан станци барих төсөл хэрэгжих гэж байна. Төсөл хэрэгжихэд үүсэх усан сангийн нийт талбай 10000 га. Түүнээс Баяннуур сумын 6200 га, Өмнөговь сумын 3800 га газар үүсэх усан сангийн талбайд хамрагдаж байна. Үүнээс нутгийн хил хязгаарыг цагаан муруйгаар тусгаарлав.




Зураг 3. Усан цахилгаан станци барих газрын усан сан үүсэх талбай, нийт 10000 га


А – Баяннуур сумын нутаг 6200 га, Б – Өмнөговь сумын нутаг 3800 га.

Зураг 3-аас харахад Усан цахилгаан станцийн нийт 10000 га талбайн 6200 га буюу 62%-ийг Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын нутаг, 3200 га буюу 38%-ийг Увс аймгийн Өмнөговь сумын нутаг тус тус эзэлж байна.


Үр дүн: Станц барихад үүсэх усан сангийн газарт одоо байгаа хот-айлын байршилд судалгаа хийсэн цэгүүдийг “улаан” өнгийн цэгүүдээр дугаарын хамт тусгасан ерөнхий байдлыг газрын зурагт харуулав.




Зураг 4. Орон зайн тархалт (Нянгийн тоо)



Зураг 5. Орон зайн тархалт (Анаэроб)



Зураг 6. Орон зайн тархалт (Гэдэсний савханцар)



Зураг 7. Орон зайн тархалт (Нянгийн тоо)

Баяннуур сумын хувьд гэдэсний савханцраар “бага” бохирдсон талбайн хэмжээ 266.6 га байж, нийт талбайн 4.3%-ийг, “дунд” бохирдсоных 177.1 га болж тэр нь 2.8%-ийг, анаэроб (Cl.perfringens) нянгаар “бага” бохирдсон 86 га талбай нь 6200 га талбайн 1.4%-ийг тус тус эзэлж байна.

Өмнөговь сумын хувьд гэдэсний савханцраар “бага” бохирдсон талбайн хэмжээ 77,4 га байж, нийт 3800 га талбайн 2.0%-ийг, “дунд” бохирдсоных 261.4 га буюу 6.9%-ийг, “их”

бохирдсоных (Улиаст бригад) 0.5 га буюу 0.01% -ийг тус тус эзэлж байна. Харин анаэроб (*Cl.perfringens*) нянгаар бохирдсон талбай энэ удаагийн судалгаагаар илрээгүй.

Хоёр сумын нийт 10000 га талбайн 783 га буюу 7.8% нь алаг цоог тархалттайгаар “багаас дунд” түвшинд бохирдолтой гэж гарлаа.

1.2.1 Дүгнэлт

- Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц баригдах төсөлд Ховд голын голдирлоор Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын 6200 га, Увс аймгийн Өмнөговь сумын 3800 га нийт 10000 га талбай станцын усан сан үүсэх талбайд өртөж байна.
- Баяннуур сумын дээр дурдсан талбайн хөрсний 0-10 см-ын гүнд гэдэсний савханцраар “бага” бохирдсон талбайн хэмжээ 266.6 га (4.3%), “дунд” бохирдсон 177.1 га (2.8%), анаэроб (*Cl.perfringens*) нянгаар “бага” бохирдсон 86 га (1.4%) талбай хамрагдаж байна.
- Өмнөговь сумын хувьд гэдэсний савханцраар “бага” бохирдсон талбайн хэмжээ 77.4 га (2.0%), “дунд” бохирдсон талбай 261.4 га (6.9%), “их” бохирдсон талбай 0.5 га (0.01%) байж тэр нь бага сургуультай Улиаст бригадын хойт захад илэрч байна.
- Өмнөговь сумын судалсан талбайд анаэроб (*Cl.perfringens*) нянгаар бохирдсон газар байхгүй байна.
- Хоёр сумын нийт 10000 га талбайн 783 га (7.8%) газрын хөрс нь гэдэсний савханцар болон анаэробын нянгийн бохирдлоор толбо ба хэсэгчилсэн зурвас байдлаар бохирдсон төлөв байдал анхны судалгаагаар ажиглагдлаа.
- Нийт нуур үүсэх талбайн 7.8% багаас дунд хэмжээнд илэрсэн иймд нуур үүсэж хуримтлагдахад нөлөөлөл бага байна.
- Нуур үүсэх хүртэл гэдэсний савханцар болон анаэробын илэрсэн газруудыг сонгон авч зуны дэлгэр цагт хяналт, шинжилгээ хийх шаардлагатай.

1.2.2 Зөвлөмж

- Бохирдолтой талбайн хэмжээг газрын гадаргуун төлөв байдал (рельеф), гуу жалга, намагжсан байдал, иргэд болон малчдын газар ашиглаж буй шинж зэрэг өнгөц ажиглалт судалгаагаар тодорхойлсон. Иймд нянгийн тархалтын талбайн хэмжээг нуур үүсгэх хүртэл дулааны улиралд хяналт шинжилгээ хийх хэрэгтэй.
- Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын нутагт байрлах 22, 23, 70, 75, 76, 125, 126, 129, 130, 136, 139 дугаар айлууд, Увс аймгийн Өмнөговь сумын нутагт байрлах 11, 17, 23, 26, 38, 41, 52, 54, 61, 67, 68, 69, 70, 73, 87, 108, 109, 110, 111, 113, байршлуудыг зуны дэлгэр цагт хяналт шинжилгээ хийх шаардлагатай.
- Судалгааны явцад гэдэсний савханцар болон анаэроб илэрсэн газруудад зуны дэлгэр цагт хөрсний гүн үе давхаргад агуулагдах нянгийн тоо, зэрэглэлийг судлах шаардлагатай.
- Нийт ус хурах талбайд байгаа Баян-Өлгий аймгийн Баяннуур сум, Увс аймгийн Өмнөговь сумын нутагт байрлах нийт 270 айлын өвөлжөө, хаваржааны өтөг бууцыг техник хэрэгсэл ашиглаж 1.5м орчим хуулан нуур үүсэх талбайгаас холдуулах шаардлагатай.
- 270 айлын өвөлжөө хаваржаанаас хуулан авсан өтөг бууцыг овоолго үүсгэж хатаах шаардлагатай. Өтөг бууцыг хатааснаар дараа нь бордоо болгон ашиглах боломжтой.
- Өтөг бууцыг тусгай талбай дээр хурааж хатаах тул зориулалтын талбай бий болгох шаардлагатай.

1.3 Төслийн талбай дахь сээр нуруутан амьтдын судалгаа

Төв Азийн гадагш урсгалгүй ай савын голуудын дотроос хамгийн элбэг устай нь Ховд гол гэж үздэг. Ховд гол Монгол Алтайн ноён оргил Алтай таван богдын зүүн өмнөд хажуугаас эх авч урсдаг Цагаан Ховд, Хар Ховд хэмээх голуудыг Ховд голын эх гэж үздэг. Ховд голын урт нь 516 км, ус хуримтлуулах савын талбай 58000 км² орчим, усны унал километр тутамд ойролцоогоор 2 метр тул урсгалын хурд ихтэй голын нэг. Ховд голд Алтайн их хур цас мөсөн эх авч урсах Цагаан гол, Согоогийн гол, Сагсай, Бөхмөрөн, Өвдөг, Шивэр, Буянт зэрэг голууд цутгадаг тул усны нөөц ихтэй. Ховд гол 10-р сарын сүүлчээр захлан улмаар хөлдөж 4-р сарын сүүлчээр гэсдэг байна. Ингэж гол хөлдөх ба гэсэх үед Ховд голын экосистемийн бүрэлдэхүүн хэсэг болох хөхтөн амьтад, усны болон хуурай газрын амьдралтай, суурин шувууд, мөлхөгч амьтад, усны шавьж зэрэг олон зүйлийн амьтдын улирлын амьдрал ээлжлэн өөрчлөгдсөөр иржээ.

Ховд голын дагууд бургас, улиас, чацаргана, харгана зэрэг модлог болон сөөглөг ургамал, дэрс, зэгс зэрэг олон зүйлийн ургамал шигүү ургадаг тул тэнд тархан идээших амьтдын зүйлийн олон янз байдал сайтай нилээд нийлмэл экосистем нь юм.

1.3.1 Судалгааны арга зүй

- 1.Шерман амьд баригчийг шугаман дизайнаар байршуулах арга зүй
- 2.Шерман амьд баригчийг дөрвөлжин грид (Square Grid) дизайны арга зүй
- 3.Шугаман замналын (Line transect) арга зүй
- 4.Зурвас замналын (Strip transect) арга зүй

Маршрут: Хээрийн судалгааны явцад Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум, Мянгад сумын чацаргант баг, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын 1-р баг, Увс аймгийн Өмнөговь сумын Улиастай баг зэрэг нутгуудыг хамарсан 900 гаруй км маршрутын судалгаа хийж дараах замналаар явжээ. Үүнд:

УБ → Ховд → Эрдэнэбүрэн сум → Шижигтийн хавцал → Эрдэнэбүрэн сум → Мянгад сумын гүүр → Мянгад сумын Чацаргант баг → Хар бураа → Шар цэхээ → Хөх хөтөл → Улиастай багийн төв → Баяннуур сумын голын зүүн тал → Цагаан гаталга → Хавцлын хойт ам → Далан босгох газар → Хөх хөтөл → Хавцлын урд уул → Ховд гол Мянгадын гүүр → Буянт сум → Ховд → гэсэн маршрутаар ажиллаж хээрийн судалгааг хийж гүйцэтгэсэн байна.

1.3.2 Хөхтөн амьтдын зүйлийн бүрэлдэхүүн

Хүснэгт 2. Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын Хавцлаас дээш үүсэх нуур орчимд тархсан хөхтөн амьтдын зүйлийн бүрэлдэхүүн, тэдгээрийн ховордлын зэрэглэл

№	Зүйлийн монгол нэр	Зүйлийн шинжлэх ухааны нэр	CITES	Олон улсын	Бүс нутгийн	Монголын улсаан ном	Тайлбар
Нэг. Шавьж идэштний баг – <i>Ordo insectivora</i>							
1	Цармын атаахай	<i>Sorex tundrensis</i>		АӨ	МД		
2	Дааган атаахай	<i>Sorex caecutiens</i>		АӨ	АӨ		
3	Өөдсөн атаахай	<i>Sorex minutissimus</i>		АӨ	МД		
4	Нугын малтаахай	<i>Crocidura suaveolens</i>		АӨ	ҮХ		
5	Усч гэрэлзгэнэ	<i>Neomys fodiens</i>		АӨ	АӨ		
6	Дэлдэн зараа	<i>Hemiechinus auritus</i>		АӨ	АӨ		

Хоёр. Сарьсан багваахайн баг – Ordo Chiroptera							
7	Говийн сармаахай	<i>Eptesicus gobiensis</i>		АӨ	АӨ		
8	Бүрэнхийч багваахай	<i>Nyctalus noctula</i>		АӨ	МД		Ховд голд
9	Уссаг багваахай	<i>Myotis petax</i>		АӨ	АӨ		
10	Сахалт багваахай	<i>Myotis davidii</i>		АӨ	АӨ		
11	Саарал соотон багваахай	<i>Plecotus kozlovi</i>		АӨ	МД		
Гурав. Туулай хэлбэртний баг – Ordo Lagomorpha							
12	Бор туулай	<i>Lepus tolai</i>		АӨ	АӨ		
13	Дагуур огдой	<i>Ochotona daurica</i>		АӨ	АӨ		
14	Монгол огдой	<i>Ochotona pallasii</i>		АӨ	АӨ		
Дөрөв. Мэрэгчдийн баг – Ordo Rodentia							
15	Бозлог зурам	<i>Spermophilus pallidicauda</i>		АӨ	АӨ		
16	Азийн минж	<i>Castor fiber</i>		АӨ	УБ	+	ховор
17	Мэхээрч оготно	<i>Microtus oeconomus</i>		АӨ	АӨ		
18	Зүлгийн оготно	<i>Microtus limnophilus</i>		АӨ	МД		
19	Тавшгар барагчин	<i>Alticola strelzowi</i>		АӨ	МД		
20	Говь-Алтайн барагчин	<i>Alticola barakshin</i>		АӨ	МД		
21	Төвд ов	<i>Eolagurus przewalskii</i>		АӨ	МД		
22	Ондатр	<i>Ondatra zibethicus</i>		АӨ	МД		
23	Сохдой оготно	<i>Ellobius tancrei</i>		АӨ	АӨ		
24	Цомч шишүүхэй	<i>Allocricetulus curtatus</i>		АӨ	АӨ		
25	Урт сүүлт шишүүхэй	<i>Cricetulus longicaudatus</i>		АӨ	АӨ		
26	Орог зусаг	<i>Phodopus campbelli</i>		АӨ	АӨ		
27	Элсний зусаг	<i>Phodopus roborovskii</i>		АӨ	АӨ		
28	Монгол чичүүл	<i>Meriones unguiculatus</i>		АӨ	АӨ		
29	Шар чичүүл	<i>Meriones meridianus</i>		АӨ	АӨ		
30	Гэрийн хулгана	<i>Mus musculus</i>		АӨ	ҮХ		
31	Говийн алагдаахай	<i>Allactaga bullata</i>		АӨ	МД		
32	Сибирь алагдаахай	<i>Allactaga sibirica</i>		АӨ	АӨ		
33	Таван хуруут атигдаахай	<i>Cardiocranius paradoxus</i>		МД	МД	+	
34	Элсч савагдаахай	<i>Dipus sagitta</i>		АӨ	АӨ		
35	Монгол даахай	<i>Stylodipis andrewsi</i>		АӨ	АӨ		
Тав. Махчдын баг – Ordo Carnivora							
36	Хярс	<i>Vulpes corsac</i>		АӨ	АӨ		
37	Шар үнэг	<i>Vulpes vulpes</i>		АӨ	АӨ		
38	Саарал чоно	<i>Canis lupus</i>	II	АӨ	ХБ		
39	Халздай дорго	<i>Meles leucurus</i>		АӨ	АӨ		
40	Эрээн хүрнэ	<i>Vormela peregusna</i>		ЭМ	МД	+	ховор
41	Өмхий хүрнэ	<i>Mustela eversmanni</i>		АӨ	АӨ		
42	Хотны үен	<i>Mustela nivalis</i>		АӨ	АӨ		
43	Цагаан үен	<i>Mustela ermine</i>		АӨ	АӨ		
44	Хээрийн солонго	<i>Mustela altaica</i>		АӨ	АӨ		
45	Хадны суусар	<i>Martes foina</i>		АӨ	ХБ	+	ховор
46	Шилүүс мий	<i>Lynx lynx</i>	II	АӨ	ХБ		ховор

47	Мануул мий	<i>Odocoileus manul</i>	II	ХБ	ХБ		
48	Цоохор ирвэс	<i>Panthera uncia</i>	I	ЭМ	УБ	+	CMS-I
Зургаа. Туруутны баг – Ordo Artiodactyla							
49	Зэгсний гахай	<i>Sus scrofa</i>		ХБ	УБ	+	ховор
50	Янгир	<i>Capra sibirica</i>		ЭМ	ХБ	+	
51	Аргаль	<i>Ovis ammon</i>	II	ХБ	УБ	+	

Тайлбар: CITES – Зэрлэг амьтан ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенци; CMS –Нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах конвенци; АӨ-анхааралд өртөхөөргүй; МД-мэдээлэл дутмаг; ХБ-ховордож болзошгүй; УБ-устаж болзошгүй; ЭМ-эмзэг; ҮХ-үнэлгээ хийгдээгүй.

Хүснэгт 2-оос үзэхэд Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц баригдах Шижигтийн Хавцал, түүний орчимд нийтдээ 6 багт хамаарагдах 51 зүйлийн хөхтөн амьтад тархжээ. Үүний дотор шавьж идэштэн 6 зүйл, сарьсан багваахай 5 зүйл, туулай хэлбэртэн 3 зүйл, мэрэгчид 21 зүйл, махчид 13 зүйл, туруутан 3 зүйл тус тус тархжээ.

Эдгээрийг Дэлхийн байгаль хамгаалах холбооноос гаргасан Улаан дансны үнэлгээгээр ховордлын зэргээр нь анализ хийж үзвэл: нүүдлийн зүйлийг хамгаалах олон улсын конвенцийн I хавсралт бүртгэгдсэн 1 зүйл (ирвэс), Зэрлэг амьтан ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн I хавсралтанд бүртгэгдсэн 1 зүйл (ирвэс), II хавсралтанд бүртгэгдсэн 4 зүйл (чоно, мануул, шилүүс, аргаль), олон улсын хэмжээнд анхааралд өртөхөөргүй гэж үнэлэгдсэн 44 зүйл, ховордож болзошгүй гэж үнэлэгдсэн 3 зүйл (зэгсний гахай, мануул, аргаль) эмзэг гэж үнэлэгдсэн 3 зүйл (янгир, ирвэс, эрэн хүрнэ), мэдээлэл дутмаг гэж үнэлэгдсэн 1 зүйл (таван хуруут атигдаахай) тус тус байна.

Харин бүс нутгийн хэмжээнд анхааралд өртөхөөргүй гэж үнэлэгдсэн 27 зүйл, ховордож болзошгүй гэж үнэлэгдсэн 5 зүйл (янгир, мануул, шилүүс, хадны суусар, чоно), устаж болзошгүй 4 зүйл (минж, аргаль, зэгсний гахай, ирвэс), мэдээлэл дутмаг гэж үнэлэгдсэн 12 зүйл, Монголын Улаан номонд орсон 7 зүйл (аргаль, янгир, зэгсний гахай, ирвэс, хадны суусар, эрэн хүрнэ, минж) тус тус байна.

Эдгээрийн дотор зөвхөн Ховд голын орчимд тархсан, усан цахилгаан станцын төслийн үйл ажиллагаанд өртөгдөх ховор амьтад нь зэгсний гахай, янгир, минж, ирвэс, шилүүс, хадны суусар, бүрэнхийн хонгор багваахай зэрэг Ховд голын бүс нутгийн ховор амьтад байна. Ховд голын эдгээр ховор амьтад усан цахилгаан станцын зөвхөн зам, барилга, гүүрэн байгууламжийн явцын ажлууд сөрөг нөлөө үзүүлсэнээс шалтгаалж амьдрах орчин өөрчлөгдөн нүүж шилжих болно. Харин эдгээр хөхтөн амьтад үүсмэл нуурын нөлөөнд харьцангуй бага өртөх юм.

Хүснэгт 3. Ховд голын УЦС-ын далангаас дээш үүсэх нуурын нөлөөнд өртөх шөнийн идэвхтэй жижиг хөхтөн амьтдын зүйлийн тоо толгойн үзүүлэлт (нийт 800 занга/хоногт ноогдох тоогоор)

ДД	Шинжлэх ухааны нэр	Монгол нэр	Барьсан бодгалийн тоо	100 занга/хоногт ноогдох элбэгшил	Ховордлын зэрэг	Үүсмэл нуурт өртөх магадлал
Шавьж идэштэн						
1	<i>Sorex tundrensis</i>	Цармын атаахай	6	0.7	хэвийн	Их өртөнө
2	<i>Sorex caecutiens</i>	Дааган атаахай	7	0.1	ховор	Их өртөнө

3	<i>Sorex minutissimus</i>	Өөдсөн атаахай	9	1.1	Хэвийн	Их өртөнө
4	<i>Neomys fodiens</i>	Усч гэрэлзгэнэ	-	-	ховор	Их өртөнө
5	<i>Crocidura suaveolens</i>	Сибирь малтаахай	2	0.3	ховор	Их өртөнө
6	<i>Hemiechiinus auritus</i>	Дэлдэн зараа	-	-	Хэвийн	Их өртөнө
Сарьсан багваахай						
1	<i>Eptesicus gobiensis</i>	Говийн сармаахай	-	-	Хэвийн	Бага өртөнө
2	<i>Nyctalus noctula</i>	Бүрэнхийч багваахай	-	-	хэвийн	Бага өртөнө
3	<i>Myotis petax</i>	Уссаг багваахай	-	-	хэвийн	Бага өртөнө
4	<i>Myotis davidii</i>	Сахалт багваахай	-	-	хэвийн	Бага өртөнө
5	<i>Plecotus kozlovi</i>	Саарал соотон багваахай	-	-	хэвийн	Бага өртөнө
Шөнийн мэргэгчид						
1	<i>Microtus limnophilus</i>	Зүлгийн оготно	10	1.3	Хэвийн	Их өртөнө
2	<i>Alticola strelzowi</i>	Тавшгар барагчин	6	0.8	Хэвийн	Бага өртөнө
3	<i>Alticola barakshin</i>	Говь-Алтайн барагчин	8	1.0	Хэвийн	Бага өртөнө
4	<i>Allocricetulus curtatus</i>	Цомч шишүүхэй	11	1.3	Хэвийн	Их өртөнө
5	<i>Cricetulus longicaudatus</i>	Урт сүүлт шишүүхэй	9	1.1	Хэвийн	Их өртөнө
6	<i>Phodopus campbelli</i>	Орог зусаг	17	2.1	Хэвийн	Их өртөнө
7	<i>Phodopus roborovskii</i>	Элсний зусаг	15	1.8	Хэвийн	Их өртөнө
8	<i>Meriones unguiculatus</i>	Монгол чичүүл	11	1.3	Хэвийн	Их өртөнө
9	<i>Meriones meridianus</i>	Шар чичүүл	16	2.0	Хэвийн	Их өртөнө
10	<i>Mus musculus</i>	Гэрийн хулгана	12	1.5	хэвийн	Их өртөнө
11	<i>Microtus oeconomus</i>	Мэхээрч оготно	9	1.4	Хэвийн	Их өртөнө
	ДҮН		148	17.8		

Хүснэгт 3-аас үзэхэд 10 хоногийн туршид 80 занга ажилуулахад бид 15 зүйлийн жижиг хөхтөн амьтдыг барив. Харин судалгааны явцад баригдаагүй боловч тэр орчинд байдаг 7 зүйлийг нэмбэл нийт 22 зүйлийн жижиг хөхтөн амьтад байна. Эдгээр 22 зүйлийн шөнийн идэвхтэй жижиг хөхтөн амьтдыг тоо толгойн төлөв байдлыг нь авч үзвэл 19 зүйл нь тооны хувьд хэвийн, ховор тохиолдох 3 зүйл тус тус байна. Харин Монгол орны хэмжээнд ховорт тохиолдох усч гэрэлзгэнэ хэмээх шавьж идэштэн байна.

Харин эдгээр шөнийн идэвхтэй жижиг хөхтөн амьтад үүсмэл нуурын нөлөөнд өртөх байдлыг үнэлж үзвэл 15 зүйл нь их өртөх ба 7 зүйл л бага өртөх магадлалтай байна. Эдгээр 15 зүйл нь шөнийн идэвхтэй, нүхний амьдралтай, Ховд голын татмын нугын биотопд байршин амьдардаг жижиг биетэй хөхтөн амьтад байна. Харин 5 зүйлийн сарьсан багваахай, 2 зүйлийн барагчин үүсмэл нуурын нөлөөнд харьцангуй бага өртөхөөр байна.

Хүснэгт 4. Эрдэнэбүрэнгийн УЦС-ын далангаас дээш орших татмын нугын биотопд тохиолдох өдрийн идэвхтэй жижиг хөхтөн амьтдын зүйлийн тоо толгойн үзүүлэлт

ДД	Хөхтөн амьтдын зүйлийн нэр	Тооллогын талбай (га-гаар)	Тоологдсон бодгалийн тоо	1га дахь нягтшил	Тоо толгойн үнэлгээ	Үүсмэл нуурт өртөх эсэх
<i>Туулай хэлбэртэн</i>						
1	Бор туулай	25	2	0.08	Элбэг	Бага өртөнө
2	Дагуур огдой	25	4	0.16	Элбэг	Их өртөнө
3	Монгол огдой	25	8	0.32	Элбэг	Их өртөнө
<i>Мэрэгч, махчид</i>						
4	Монгол чичүүл	25	16	0.64	Элбэг	Их өртөнө
5	Шар чичүүл	25	9	0.36	Элбэг	Их өртөнө
6	Хярс	25	1	0.04	Элбэг	Бага өртөнө
7	Үнэг	25	-	0	Элбэг	Бага өртөнө

Хүснэгт 4-өөс үзэхэд Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын далангаас дээш үүсэх нуурын нөлөөнд өртөгдөх өдрийн идэвхтэй 7 зүйлийн хөхтөн амьтад бидний хээрийн судалгааны явцад бүртгэгдэв. Эдгээр 7 зүйлийн хөхтөн амьтдын дотор туулай хэлбэртэн 3 зүйл, мэрэгч 2 зүйл, махчин амьтан 2 зүйл тус тус байсан бөгөөд эдгээрийн дотор Монгол орны хэмжээнд болон Ховдын бүс нутгийн хэмжээнд ховор статустай амьтан байхгүй. Дээрх амьтад тоо толгойн хувьд элбэг, тархац нутгийн хувьд өргөн амьтад юм.

Харин эдгээрийн дотор усан цахилгаан станцын үйл ажиллагаанаас үүсэх нуурын нөлөөнд их өртөж амьдрах орчин, нүх ноохой нь усанд автагдах 4 зүйл, бага өртөгдөх 3 зүйл байна. Тухайлбал, хярс, үнэг, туулай зэрэг амьтад нуурын уснаас дайжих чадвартай тул харьцангуй бага өртөнө.

1.3.3 Шижигтийн хавцал орчмын шувуудын зүйлийн бүрэлдэхүүн, орших хэлбэр

Шижигтийн хавцал орчим буюу төсөл хэрэгжих талбайд 45 зүйл шувууг бүртгэсэн. Төсөл хэрэгжих нутагт олон улсын улаан дансны ангилал (IUCN, Red List)-аар ховордож болзошгүй **Алтайн хойлог** *Tetraogallus altaicus* (Gebler, 1836), **Гургуул** *Phasianus colchicus* (Linnaeus, 1758), эмзэг бөгөөд устаж болзошгүй **Идлэг шонхор** *Falco cherrug* (Gray, 1834), эмзэг **Хулан жороо** *Podoces hendersoni* (Hume, 1871), **Ооч ёл** *Gypaetus barbatus* (Linnaeus, 1758), **Нөмрөг тас** *Aegypius monachus* (Linnaeus, 1766) гэсэн зүйлүүд байна (Диаграм 1).



Түүнчлэн, CITES болон CMS-ийн конвенцийн I хавсралтад орсон *Gypaetus barbatus* (Linnaeus, 1758)

Ооч ёл, *Aegypius monachus* (Linnaeus, 1766) Нөмрөг тас, *Aquila chrysaetos* (Linnaeus, 1758) Цармын бүргэд, *Hieraaetus pennatus* (Gmelin, 1788) Бахим бүргэд, *Circus cyaneus* (Linnaeus, 1766) Саарал хулд, *Buteo lagopus* (Pontoppidan, 1763) Тарлан сар, *Buteo hemilasius* (Temminck & Schlegel, 1844) Шилийн сар, II хавсралтанд орсон *Cygnus cygnus* (Linnaeus, 1758) Гангар хун, *Falco tinnunculus* (Linnaeus, 1758) Начин шонхор, *Falco subbuteo* (Linnaeus, 1758) Шууман шонхор, *Falco cherrug* (Gray, 1834) Идлэг шонхор энэ нутагт амьдардаг.



Шижигтийн хавцал орчмын шувуудын урт хугацааны мониторинг хийхэд чухал ач холбогдолтой гарал үүслийн олон янз байдлыг диаграм 2-т үзүүлээ. Төслийн талбайд палеарктикийн гарал үүсэлтэй 11 зүйл, Монгол, Монгол-Түвдийн 15 зүйл байгаа нь төрөл зүйлийн олон янз байдлыг илэрхийлж, Палеарктикийн өргөн бүс нутаг болон Монгол-Төвдийн өвөрмөц газар нутгийн хоорондох холбоос нутаг гэдгийг илэрхийлж байгаа

бөгөөд экологийн чухал ач холбогдолтой бүс нутаг юм. Гарал үүслийн байдлыг тодорхойлох шаардлагатай 8 зүйлийг энэ бүс нутагт улирал бүрт ажиглалт хийж тодруулах шаардлагатай.

Төсөл хэрэгжих талбайн шувуудаас суурин амьдралтай 25 зүйл, нүүдлийн 17 зүйл, өндөглөн зусдаг 38 зүйл, дайрч өнгөрдөг 3 зүйл, тохиолдлын 1 зүйл, өвөл орж ирдэг 2 зүйл тус тус бүртгэгдсэн байна.

1.3.4 Шувуудын хээрийн судалгааны үр дүн

Хээрийн судалгааны явцад бүртгэгдсэн шувуудын амьдрах орчин, судалгааны талбайд тохиолдох ландшафтын онцлог, төсөл хэрэгжих талбайд элбэг эсэхийг бичиглэл үйлдэх замаар тодорхойлон гаргасныг Хүснэгт 5-т үзүүлэв. Төсөл хэрэгжих талбайн хэмжээнд Саарал хулд, Шууман шонхор, Бургасны уран шувуу нэн ховор тохиолдоно. Мөн Алтан хойлог, Хахилаг, Эгэл шар шувуу, Цармын бүргэд, Бахим бүргэд, Тарлан сар, Шилийн сар, Идлэг шонхор, Хулан жороо, Хадны жижир, Монгол хайруулдай, Годлевскийн шийхнүүхэй, Үүрэн сүүлт бужмар, Буулгат хөмрөг ховор тохиолдох зүйлүүдэд багтдаг.

Хүснэгт 5. Төслийн талбай дахь шувуудын амьдрах орчин, тоо толгойн байдал

дд	Монгол нэр	Амьдрах орчин, тохиодол газар	Төслийн талбайд элбэг/ховор
1	Алтайн хойлог	ХА, уулын хяр, тагийн бүсэд	Ховор
2	Хахилаг	ХА, Сэжигтийн хавцалд, нураг чулуутай энгэрт	Ховор
3	Гургуул	МБ, голын хөндий, Шар цэхээгээс зүүн тийш Баян нуур хүртэл аралтай хэсэгт	Элбэг
4	Дагуур ятуу	ХА, уулын бэлд	Элбэг
5	Гангар хун	УН, голд	Элбэг
6	Хөхвөр тагтаа	ХА, модтой хэсгээр	Элбэг
7	Ногтруу	ГЦ, нам дор Болжмийн хөдөө	Элбэг
8	Хурын ураацай	ХА, голын эргээ	Элбэг

9	Эгэл шаршувуу	ХА, хадны хөндийд	Ховор
10	Ооч ёл	ӨУ, Сэжигтийн хавцалын эхэнд	Элбэг
11	Нөмрөг тас	ӨУ, Сэжигтийн хавцлын эхэнд	Элбэг
12	Цармын бүргэд	ӨУ, Сэжигтийн хавцалд	Ховор
13	Бахим бүргэд	МБ, уулс хоорондын хээрийн бүсэд	Ховор
14	Саарал хулд	УН, голын хөндийд	Нэн ховор
15	Тарлан сар	МБ, голын хөндийд	Ховор
16	Шилийн сар	ХТ, голын хөндийд	Ховор
17	Начин шонхор	ХТ, хээр, голын хөндийн харганатай хэсгээр	Элбэг
18	Шууман шонхор	МБ, голын хөндийн харганатай буланд	Нэн ховор
19	Идлэг шонхор	ХТ, голын харганатай хөндийд	Ховор
20	Бөвөөлжин өвөөлж	ХА, бут сөөг, харганатай хэсэгт	Элбэг
21	Эгэл шаргач	МБ, уулын хяр хад асгатай хэсэгт	Элбэг
22	Хулан жороо	ГЦ, Хөх хөтлийн даваа орчимд	Ховор
23	Алаг шаазгай	МБ, улиас дагасан голын хөдид	Элбэг
24	Улаан хошуут	ӨУ, уулын хээрийн хадтай энгэрээр	Элбэг
25	Хон хэрээ	МБ, голын хөндий, уулын хээр	Элбэг
26	Хар хэрээ	МБ, голын хөндий, уулын хээр	Элбэг
27	Их хөх бух	МБ, шугуйд	Элбэг
28	Бургасны уран шувуу	МБ, шугуйд	Нэн ховор
29	Дэрсний жиргэмэл	ХТ, тал хээрт	Элбэг
30	Эвэрт болжмор	ХТ, уулын бэл, уулын хээрт	Элбэг
31	Асрын алтанхараацай	УН, голын эрэг	Элбэг
32	Эргийн хараацай	УН, голын эрэг	Элбэг
33	Хадны жижир	ӨУ, хадтай толгодоор	Ховор
34	Эгэл галсүүлт	ӨУ, хадтай толгодоор	Элбэг
35	Адууч чогчиг	ХА, хадтай толгодоор	Элбэг
36	Шарга хайруулдай	ХА, хадтай толгод, тагийн доод хэсгээр	Элбэг
37	Монгол хайруулдай	ӨУ, Сэжигтийн хавцлын хадтай толгодоод сүрэглэнэ	Ховор
38	Хээрийн боршувуу	МБ, голын хөндийн харганат ба бургасан шугуйд	Элбэг
39	Годлевскийн шийхнүүхэй	МБ, голын хөндийн харганат ба бургасан шугуйд	Ховор
40	Уулын цэгцгий	ӨУ, гол хөндий, ууланд	Элбэг
41	Цасч хөмрөг	ХА, хад асгатай хэсгээр	Элбэг
42	Буулгат хөмрөг	МБ, хад асганы мод сөөгтэй хэсэгт	Ховор
43	Үүрэн сүүлт бужмар	МБ, хадтай хэсгүүдээр	Ховор
44	Улаан бужмар	МБ, хадтай хэсгүүдээр	Элбэг
45	Цагаан хөмсөгт хөмрөг	МБ, бургасан шугуйтай хэсэгт	Элбэг

Төсөл хэрэгжих газар нутагт тодорхойлогдсон 45 зүйл шувууг уг талбайн хүрээнд элбэг, ховор байгааг үнэлж Хүснэгт 5-т оруулснаас үзэхэд элбэг нь 28 зүйл, ховор нь 14 зүйл, нэн ховор нь 3 зүйл байна.

1.3.5 Дүгнэлт

- Ховд гол, түүний сав газарт хамрагдах Сэжигтийн Хавцал орчмын нутаг болон төслийн талбайд өмнөх судлаачдын болон бидний хээрийн судалгаагаар 51 зүйлийн хөхтөн амьтад тархсан нь Монгол орны хөхтөн амьтны зүйлүүдийн 36.4 хувийг эзэлж байна. Энэ нь уг бүс

нутаг байгалийн тогтоцын хувьд олон янзын амьдрах орчныг агуулдагаас шалтгаалан хөхтөн амьтдын зүйлийн олон янз байдал харьцангуй өндөр байдагтай холбоотой.

- Эдгээрийн дотор CITES буюу Зэрлэг амьтан ургамлын төрөл зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Вашингтоны конвенцид бүртгэгдсэн 5 зүйл (Шилүүс, Ирвэс, Саарал чоно, Мануул, Аргаль), харин CMS буюу Нүүдэллэдэг зүйлийн конвенцид бүртгэлтэй Ирвэс зэрэг олон улсын конвенцид бүртгэгдсэн ховор амьтад байгааг судалгаагаар тогтоов. Түүнээс гадна Монгол улсын Улаан ном, засгийн газрын тогтоолоор ховор амьтны жагсаалтанд бүртгэгдсэн, бүс нутагт устаж болзошгүй гэж үнэлэгдсэн 4 зүйл (Азийн минж, ирвэс, зэгсний зэрлэг гахай, аргаль) амьтад тус тус тархжээ. Эдгээрийг Дэлхийн байгаль хамгаалах холбооноос гаргасан Улаан дансны үнэлгээгээр ховордлын зэргээр нь анализ хийж үзвэл: нүүдлийн зүйлийг хамгаалах олон улсын конвенцийн I хавсралт бүртгэгдсэн 1 зүйл (ирвэс), Зэрлэг амьтан ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн I хавсралтанд бүртгэгдсэн 1 зүйл (ирвэс), II хавсралтанд бүртгэгдсэн 4 зүйл (чоно, мануул, шилүүс, аргаль), олон улсын хэмжээнд анхааралд өртөхөөргүй гэж үнэлэгдсэн 44 зүйл, ховордож болзошгүй гэж үнэлэгдсэн 3 зүйл (зэгсний гахай, мануул, аргаль) эмзэг гэж үнэлэгдсэн 3 зүйл (янгир, ирвэс, эрэн хүрнэ), мэдээлэл дутмаг гэж үнэлэгдсэн 1 зүйл (таван хуруут атигдахай) тус тус байна.
- Харин бүс нутгийн хэмжээнд анхааралд өртөхөөргүй гэж үнэлэгдсэн 27 зүйл, ховордож болзошгүй гэж үнэлэгдсэн 5 зүйл (янгир, мануул, шилүүс, хадны суусар, чоно), устаж болзошгүй 4 зүйл (минж, аргаль, зэгсний гахай, ирвэс), мэдээлэл дутмаг гэж үнэлэгдсэн 12 зүйл, Монголын Улаан номонд орсон 7 зүйл (аргаль, янгир, зэгсний гахай, ирвэс, хадны суусар, эрэн хүрнэ, минж) тус тус байна. Эдгээрийн дотор зөвхөн Ховд голын орчимд тархсан, усан цахилгаан станцын төслийн үйл ажиллагаанд өртөгдөх ховор амьтад нь зэгсний гахай, янгир, минж, ирвэс, шилүүс, хадны суусар, бүрэнхийн хонгор багваахай зэрэг Ховд голын бүс нутгийн ховор амьтад байгааг анхаарах шаардлагатай.
- Ховд голын УЦС-ын далангаас дээш үүсэх нуурын усанд маш их өртөх 13 зүйл (25.5%), их өртөх 18 (35.3%) зүйл, бага өртөх 20 зүйл (39.2%) зүйлийн хөхтөн амьтад тус тус байна. Өөрөөр хэлбэл, Ховд голын Шижигтийн хавцалын усан цахилгаан станцын уулын ажил болон үүсмэл нуурын үйл ажиллагаанд өртөхгүй амьтад гэж байхгүй. Тухайлбал, Сэжигтийн Хавцалын усан цахилгаан станцын далангаас дээш хэсэгт орших нугын биотопд тархсан, нүх ухаж суурин амьдардаг бүх жижиг хөхтөн амьтад усанд автагдана гэсэн үг. Нөгөө талаар Хавцал дотор явагдах уулын ажлын нөлөөнд 31 зүйл (68.6%) их болон бага хэмжээгээр өртөнө. Өдрийн идэвхтэй жижиг хөхтөн амьтдын дотроос хамгийн ихээр өртөх монгол огдой, барагчин, чичүүл зэрэг мэргчид, нохдын болон суусрын овгийн махчид, янгир, ирвэс зэрэг ховор амьтад шууд ба дам байдлаар өртөж, тэдгээрийн тархац байршил өөрчлөгдөх нь зайлшгүй.
- Дээр дурьдсан нүх ухаж амьдардаг, суурин амьдралтай жижиг хөхтөн амьтдыг дүйцүүлэн хамгаалах зарчмаар УЦС-ын үүсмэл нуур орчмын нийт талбайтай тэнцэх хэмжээний талбайг орон нутгийн болон Улсын Тусгай хамгаалалтад авч нутаг дэвсгэрийг өргөтгөх замаар дүйцүүлэн (Biodiversity offset) хамгаалах зайлшгүй шаардлагатай. Мөн тураг хөхтөн амьтдын хувьд ч Ховд голын хөндий нь баруун ба зүүн талын уул нуруугаа дамжин гүйх коридор нутаг болдог онцлогтой.
- Ховд голын Шижигтийн Хавцалд усан цахилгаан станц барьсанаар станц орчмын голын сав газарт тархсан тураг хөхтөн болон мах идэшт хөхтөн амьтдын тархац, байршил, шилжилт хөдөлгөөнд тодорхой өөрчлөлтүүд гарна. Тухайлбал, зэгсний гахай, янгир, ирвэс зэрэг нэн ховор амьтдын Ховд голыг хөндлөн гарах гүйдэл өөрчлөгдөнө. Үүнээс шалтгаалан тэдгээрийн тархац нутаг тасархайтах эрсдэл бий. Мөн их хэмжээний талбай

усанд автагдсанаас шалтгаалан тэдгээрийн идэш тэжээлийн нөөц тодорхой хэмжээгээр багасна. Идэш тэжээлийн нөөц хомсдвол тэдгээр амьтдын тархац байнгын байршил нутаг өөрчлөгдөх эрсдэлтэй.

- Ховд голын Шижигтийн Хавцал орчмын нутагт тархсан тураг амьтдын гол амьдрах, хоргодох орчин нь бургас, улиас, чацарганы бут, харгана, зэгс бүхий шугуй байдаг. Эндхийн амьтдын үржил явагдах газрууд нь уулын таг орчмын эгц цавчим хад, асга бүхий газрууд байдаг бөгөөд тэнд орчны өөрчлөлт болон хүн малын нөлөө харьцангуй бага юм. Гэхдээ байгалийн биотик болон абиотик нөлөө байх нь тодорхой. Харин усан станц барих үйл ажиллагааны явцад эдгээр орчинд хүний зүгээс үзүүлэх элдэв сөрөг нөлөөллийн хяналтыг сайжруулах нь чухал байна.
- Шувуудад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжийг хэрэгжүүлж, ховордож болзошгүй Алтайн хойлог *Tetraogallus altaicus* (Gebler, 1836), Гургуйл *Phasianus colchicus* (Linnaeus, 1758), эмзэг бөгөөд устаж болзошгүй Идлэг шонхор *Falco cherrug* (Gray, 1834), эмзэг Хулан жороо *Podoces hendersoni* (Hume, 1871), Ооч ёл *Gypaetus barbatus* (Linnaeus, 1758), Нөмрөг тас *Aegypius monachus* (Linnaeus, 1766) болон CITES, CMS-ийн конвенцийн I хавсралтад орсон *Gypaetus barbatus* (Linnaeus, 1758) Ооч ёл, *Aegypius monachus* (Linnaeus, 1766) Нөмрөг тас, *Aquila chrysaetos* (Linnaeus, 1758) Цармын бүргэд, *Hieraaetus pennatus* (Gmelin, 1788) Бахим бүргэд, *Circus cyaneus* (Linnaeus, 1766) Саарал хулд, *Buteo lagopus* (Pontoppidan, 1763) Тарлан сар, *Buteo hemilasius* (Temminck & Schlegel, 1844) Шилийн сар, II хавсралтанд орсон *Cygnus cygnus* (Linnaeus, 1758) Гангар хун, *Falco tinnunculus* (Linnaeus, 1758) Начин шонхор, *Falco subbuteo* (Linnaeus, 1758) Шууман шонхор, *Falco cherrug* (Gray, 1834) Идлэг шонхор гэсэн зүйлүүдийг хамгааллын арга хэмжээнд хамруулах шаардлагатай болжээ.
- Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас ус намгархаг газар хатаж, ширгэж, түүнд шүтэн амьдардаг биологийн төрөл зүйлүүдийн амьдрах орчин хүчтэй өөрчлөгдөж Ховдын гол, түүнд шүтэн амьдардаг ховор шувуудын амьдрах орчинд чухал нөлөөтэй учраас төсөл хэрэгжих бүс нутгийн экологийн тэнцвэрт байдлыг байнгын мониторинг хийх шаардлагатай гэж үзэн дараах 14 цэгийг мониторингийн цэгээр тогтоосон болно.
- Шижигтийн хавцалд буюу төсөл хэрэгжүүлэх талбайд суурин, өндөглөн үрждэг шувуудыг үржлийн улиралд нь нарийвчилсан судалгаа хийж, биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрт хулан жороо, зэрлэг гургуул, бургасны уран шувуу, алтайн хойлог зэрэг эмзэг зүйлүүдийг хамруулахдаа идэш тэжээл, үүрлэх газар зэргийг цогцоор нь авч үзэх нь чухал ач холбогдолтой.
- Ховд голын Шижигтийн Хавцал орчмын нутаг нь эргэн тойрон өндөр уул болон цөлжүү хээрийн бүсээр хүрээлэгдсэн, амьтны зүйлийн олон янз байдлын хувьд ядмаг, байгалийн нөхцөл нь эмзэг, нөхөн сэргэхэд урт хугацаа шаардах өвөрмөц орчин гэдгийг бүх шатанд анхааралдаа авч ажиллах шаардлагатай. Усан цахилгаан станц барьж Монгол орны баруун бүсийн эрчим хүчний найдвартай эх үүсвэр бий болгох нь Засгийн газрын чухал бодлогын нэг боловч энд үүсэх экологийн хохирлыг хамтад нь шийдэх зайлшгүй шаардлагатай гэж дүгнэж байна.

2 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Хүснэгт 6. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

дд	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжилтийн тайлбар
1.	Соёлын биет бус өвийн тандалт судалгаа	Төслийн хүрээнд тусгай хэрэгцээнд авсан 28000 га газар нутгийн хэмжээнд хайгуул судалгаа хийх	Угсаатны зүйн авран хамгаалах тандалт судалгааны ажлыг хийж гүйцэтгүүлэхээр 2024.07.05-ны өдөр “Түүх, угсаатны зүйн хүрээлэн”-тэй гэрээ байгуулан судалгааны тайланг 2024.11.19-ны өдөр монгол, англи хувилбараар хүлээн авсан. Тус тайлангаас 2.1-р бүлэгт товч дурдав.
2.	БОМТ-ний нэмэлт ажил Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын нутаг дахь нуур үүсэх талбайн 60 иргэний булш бунхан	Нуур үүсэх талбай дахь 60 иргэний булш бунханыг нүүлгэн шилжүүлэх	Төслийн БОМТ-нд нэмэлтээр Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслийн Баян-Өлгий аймаг Баяннуур сумын нуур үүсэх талбайд байрлах казах иргэдийн булш бунханыг нүүлгэн шилжүүлэх ажлыг “Кенжедара трейд” ХХК-тай гэрээ байгуулан, нүүлгэн шилжүүлэх ажлыг хийж гүйцэтгүүлэн, ажлын тайланг 2024.12.09-ны өдөр хүлээн авсан. Тус тайлангаас 2.2-р бүлэгт товч дурдав.

2.1 Соёлын биет бүс өв буюу Угсаатан зүйн авран хамгаалах тандалт судалгаа

Угсаатны зүйн үнэлгээ судалгааны зорилго нь тухайн бүтээн байгуулалт (ашигт малтмал, барилга, усан цахилгаан станц, аялал жуулчлалын бааз, авто болон төмөр зам, өндөр хүчдэлийн шугам гэх мэт)-ийн тусгай зөвшөөрөл талбай орчмын малчин ард иргэдийн цаашид малаа маллан аж төрөхөд бэлчээр усанд ямар нэгэн нөлөө үзүүлэх эсэх, эл сав нутгийн ойр орчмын тахилга шүтээнтэй уул усны нэр, түүх домгийг тэмдэглэх улмаар ямар ан амьтан, өвс ургамлын бүтцийн тодорхой хэмжээнд тодруулах, тухайн бүс нутагт явагдах дээр дурдсан томоохон үйл ажиллагааны үр дүн орон нутгийн иргэд, малчдын амьдралын орчин нөхцөлд хэрхэн нөлөө үзүүлэх, түүнийн сөрөг нөлөөллийг хэрхэн бага түвшинд байлгах зэрэгт орон нутгийн иргэдийн санал бодлыг тусгах, дурдсан чиглэлүүдээр үйл ажиллагаа явуулах байгууллагад санал дүгнэлтийг хүргүүлэх, шийдвэрлэхэд нөлөөлөх зорилготой юм.

Бид хээрийн судалгааг хийхдээ судлагдахууныг судалгааны үндсэн чиглэлээс хамаарч доор дурдсан байдлаар ангилж үзсэн бөгөөд үүнд:

1. Хорио цээрт газар орон
2. Тахилга, шүтлэгт орон
3. Малчдын бууц суурин

4. Эрт үеийн шашин, шүтлэгийн зан үйлт газар орон гэсэн үндсэн агуулгад хамруулан авч үзсэн болно. Харин дээрх 3-н чиглэлд хамаарах бүс нутгуудыг нийтэд нь “Соёлын Орон Зай”-т газар гэсэн үндсэн агуулгад багтаасан. Учир нь хүний амьдарч буй болон түүний үйлдэлд хамаарагдах бүс нутаг тэр чигтээ соёлын бүтээгдэхүүн болохын хувьд нийтэд нь “соёлын орон зай” гэсэн үндсэн айд хамааруулж үзсэн. Угсаатны зүйн баримтжуулалт, соёлын орон зайд нөлөөлөх нөлөөллийн судалгаа хийхдээ тухайн уул уурхайн болоод бусад төрлийн үйл ажиллагаа явуулж буй талбайгаас дээрх 3-н бүс нь хамгийн багадаа 1км зайд оршиж буй бол түүнийг нөлөөллийн бүс гэж авч үзсэн бөгөөд (жишээ нь Монгол улсад анх удаа хийгдсэн Оюу Толгой уурхайн орчинд хийгдсэн соёлын өвийн нөлөөллийн судалгааг хийхдээ тухайн талбайгаас хааш хааш 7-8км зайг хамааруулж үзэж байсан) энэ нь тухайн талбайд хийгдэх олборлолтын болон бусад үйл ажиллагааны хамрах хүрээнээс шалтгаалан дээрх нөлөөллийн бүсийн зайн хэмжээ өөрчлөгдөж болох талтай юм.

Бидний хээрийн судалгаа хийсэн бүс нутаг нь эртнээс нааш тухайн 3 аймгийн 4 сумын зарим багуудын малчдын хаваржаа, намаржаа, өвөлжөөний бүс нутаг байсаар ирсэн нь мал маллагаа, бэлчээр ашиглалтын түүхэн уламжлалыг өөртөө хадгалсан, алтайн нурууны монголчуудын соёлын нэг том орон зай болох нүүдлийн түр суурин болоод түүний орчны бүс нутаг, түүнд агуулагдах утга бэлгэдэл, хорио цээр, зан үйлийг хадгалсан газар байсаар ирсэн, одоо ч энэ шинж чанараа хадгалсаар байгаа газар юм. Тиймээс эдгээр нэр дурдагдан буй соёлын өвт газруудад усан цахилгаан станцын бүтээн байгуулалт болоод үндсэн үйл ажиллагааны явцад хүндэтгэлтэй хандах, тухайн талбайн орчимд амьдарч буй 3 аймгийн 4 сумын нэр заасан багуудын малчдад усан цахилгаан станцын аливаа үйл ажиллагааны талаар тогтмол мэдээлэл өгөх, ямар нэгэн байдлаар аливаа сөрөг нөлөөллийг бий болгохгүй ажиллах нь чухал байна.

Усан цахилгаан станцын бүтээн байгуулалт болон үндсэн аливаа үйл ажиллагаа, тэр дундаа усан сан байгуулах зэрэг үйл ажиллагаанаас шалтгаалсан аливаа нөхцөл байдал үүсэхэд орон нутгийн иргэд, малчдад дээрх үйл ажиллагааны талаар тогтмол мэдээлэл өгөх, тэдний ахуй соёл, зан заншлын өвөрмөц онцлогийг харуулсан соёлын орон зайт бүс, амьдралын орчинд нь ямар нэгэн байдлаар сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх, төслийн нэгжийн зүгээс аливаа үйл ажиллагаа явуулахдаа малчдын санал хүсэлтийг харгалзан үзэж байх нь чухал байна.

Эрдэнбүрэнгийн усан цахилгаан станцын ашиглалтын талбай, түүний эргэн тойрны нөлөөллийн бүсэд урьдчилсан байдлаар соёлын орон зайт газрууд болох малчны бууц суурин /өвөлжөө, хаваржаа/, худаг, овоо, нутаглаж буй малчин өрх, соёлын дурсгал, загас агнуурын отог, оршуулгын газар, нутгийнхы дээдэлдэг байгалийн өвөрмөж тогтоц бүхий газар гэсэн нийт 83 цэг байгааг тэмдэглэн, холбогдох эх хэрэглэгдэхүүнийг бүртгэн баримтжуулав.

Судалгаагаар Эрдэнбүрэнгийн усан цахилгаан станцын ашиглалтын талбай нь Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын Баянгол баг, Ховд аймгийн Мянгад сумын Чацаргант баг, Увс аймгийн Өмнөговь сумын Улиастай багийн нутгийг хамарч малчдын өвөлжөө, хаваржаа, зуслангийн гол нутгийг хамарч оршиж байгаа нь харагдаж байна.

Ашиглалтын талбайн бүс нутаг нь дархан цаазат ирвэс, аргаль, янгир, буга, зэгэсний гахай зэрэг амьтдын голлох бэлчээр нутаг тул нутгийн уугуул амьтны амьдралын орчинд илт сөргөөр нөлөөлөх ямар нэгэн үйл ажиллагаа явуулахгүй байхыг анхаарах шаардлагатай.

Уг ашиглалтын талбайд Увс аймгийн Өмнөговь сумын Улиастай багийн иргэдийн эртнээс тахиж, шүтэж ирсэн “Дамжиг толгойн овоо” оршиж байгаа нь соёлын өвд сөргөөр нөлөөлөх болзошгүй байна. Иймд аливаа үйл ажиллагаа эхлүүлэхдээ нутгийн иргэдэд урьдчилан мэдэгдэж, тэдний оюуны соёлын орон зайд хүндэтгэлтэй хандах, сөрөг нөлөөлөл үүсгэхгүйгээр шийдвэрлэхийг онцгойлон анхаарах шаардлагатай.


Ашиглалтын талбайн зүүн талын зурвасаас 3 км-т Увс аймгийн Өмнөговь сумын Улиастай баг, Ховд аймгийн Мянгад сумын Чацаргант багийн нутгийн заагт орших “Хөх хөтөлийн овоо”-г нутгийн иргэд хаврын эхэн сард тахидаг байна. Тиймээс нэр дурдагдан буй газруудад ямар нэгэн байдлаар усан цахилгаан станцын бүтээн байгуулалтын үйл ажиллагаанаас хамаарсан аливаа сөрөг нөлөөллийг бий болгохгүй ажиллах нь чухал.

Эрдэнэбүрэнгийн Усан Цахилгаан Станц баригдаж, тухайн бүс нутагт орон нутгийн уугуул иргэдээс гадна шинээр өөр бүс нутгаас төслийн бүтээн байгуулалт болон бусад үйл ажиллагаанд оролцохоор шинээр шилжин ирэгсдийн тоо нэмэгдэх төлөвтэй байгаа. Хэрэв энэхүү үйл явцаас шалтгаалан тухайн бүс нутагт хүн амын төвлөрөл нэмэгдсэн тохиолдолд орон нутгийн уугуул иргэдийн зүгээс тэдний уламжлалт амьдралын хэв маяг, угсаатны бүлгийн үндсэн хэв маяг, тэдний хүн амын бүтцэд сөргөөр нөлөө үзүүлэх эрсдэлтэй гэж үзэх нь харьцангуй бага буюу ирээдүйгээс хүлээх айдас байхгүй байгаа нь харагдав. Тэр дундаа Монгол улсын нутаг дэвсгэр дээрх үндэсний цөөнх болох казах иргэдийн хувьд (Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын Цэцэгт багийн казах иргэд) энэ асуудал дээр төдий л сөргөөр хүлээж авах юм уу, эсэргүүцэх зүйл ажиглагдаагүй. Хээрийн судалгаа явуулсан бүс нутаг нь Монголын баруун бүс нутгийн, тэр дундаа алтайн нурууны монголчууд болон түрэг угсаатан ард түмний нутаглаж буй газар орон болохын хувьд хэл аялгын хувьд түрэг хэл (Баяннуур сумын казах иргэдийн хэл болох казах хэл) болон баруун монголчуудын уламжлалт орон нутгийн аялгаар ярьж байна. Орон нутгийн уугуул иргэдийн уламжлалт хэл аялга нь Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын төсөл хэрэгжих эхэлснээс хойш ямар нэгэн байдлаар өөрчлөгдөх, хүн амын төвлөрөл бий болсоноос шалтгаалан устаж үгүй болох эсэх талаар орон нутгийн иргэдийн дунд ямар нэгэн айдас, болгоомжлол байхгүй нь ажиглагдав. Жишээ нь Баяннуур сумын хувьд хүн амын бүтцийн хувьд үндсэндээ казах иргэдээс бүрдэж байгаа учраас тухайн сумын ерөнхий боловсролын дунд сургуульд казах хэлийг тогтмол зааж, сургаж буй бөгөөд энэ нь хүүхэд залуусын дундах казах хэлний хэрэглээ өндөр байх нэг шалтгаан болдог байна. Мөн бусад сумуудын хувьд угсаатны бүлгийн хувьд сум бүр нэг угсаатны бүлгээс бүрдэж байгаа нь тэдний дундах нутгийн аялга болоод баруун монголчуудын аялгын хэрэглээ өндөр байна.

Тухайн төслийн талбай орчим дахь орон нутгийн уугуул иргэд, малчдын хувьд уламжлалт мал маллаагаанд усан цахилгаан станцын үйл ажиллагаа ямар нэгэн байдлаар

нөлөө үзүүлэх эрсдэлтэй байгаа тул (усан сан үүсгэх, барилга, бүтээн байгуулалтын үйл ажиллагаанаас шалтгаалсан малын бэлчээр хумигдах, хадлан тэжээл авах талбай хумигдах гэх мэт) өөр газарт шилжин, нүүдэллэж, шинэ нутагт нутаглах нь илүү зөв шийдэл гэж үзэж байна. Дээрх үндсэн асуудал болон угсаатны бүлгийн болоод угсаатны биет бус соёлын өвийн асуудалд усан цахилгаан станцын бүтээн байгуулалт шууд утгаар сөрөг нөлөө үзүүлэхгүй хэдий боловч (орон нутгийн малчид тухайн бүс нутгаас нүүж, өөр газарт хаваржаа намаржаа, өвөлжөө барьж суурьших, нутаглах) төслийн нэгжийн зүгээс эдгээр асуудалд орон нутгийн иргэд, малчид, удирдах байгууллагатай байнга санал солилцох, тэдэнд төслийн талаарх мэдээллийг тогтмол өгч байх нь зүйтэй гэж үзэж байна.

Хээрийн судалгааны үр дүнд илрүүлсэн соёлын орон зайт газар орны түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судлан шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбогдох харилцааг зохицуулах зорилттой Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн холбогдох заалтуудыг үндэслэл болгон ажиллах, тухайн орон нутгийн иргэд, малчидтай зөвшилцөж ажиллах нь чухал байна. Мөн уг соёлын орон зай бүхий талбайд усан цахилгаан станцтай холбоотой үйл ажиллагаа явуулахдаа эдгээр бүс нутгуудад амьдарч буй орон нутгийн уугуул иргэд, малчдад урьдчилан мэдэгдэх, хэрэв шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн байгууллагаар дахин судалгаа хийлгэх нь зүйтэй хэмээн үзэж байна.



Зураг 8. Эрдэнэбүрэнгийн Усан Цахилгаан Станцын үндсэн талбайд хийсэн угсаатны зүйн хээрийн судалгааны үеэр бүртгэгдсэн соёлын орон зайт бүсүүдийн байршил

2.2 Төслийн нуур үүсэх талбай дахь 60 иргэний булш бунханыг нүүлгэн шилжүүлэх

Төслийн нуур үүсэх талбайн Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын нэгдүгээр баг “Өндөр толгой” гэх газар байрлах Казах иргэдийн булш бунханыг сумын ЗДТГазраас өгсөн чиглэлийн дагуу Баяннуур сумын нэгдүгээр баг “Өнчин толгой” хэмээх газарт нүүлгэн шилжүүлэх ажлыг “Кенжедара трейд” ХХК хийж гүйцэтгэсэн. Ажлыг гүйцэтгэх хугацаанд иргэдийн ар гэр, хамаатан, садан төрлийн хүмүүстэй харилцан ярилцаж, санал хүсэлтийн дагуу шийдвэрлэж ажилласан байна.

Нийт 108 хүний бунхан буюу 60 том хүн, 48 хүүхэд байснаас 72 хүний нэрс тодорхой, 36 хүний нэр тодорхойгүй байсан байна. Нэр тодорхой 72 хүнийг хүндэтгэлийн самбарт бичиж байршуулсан байна. Ажлыг бүрэн гүйцэтгэн, иргэдийн санал гомдлыг тухай бүрт нь шийдвэрлэж, үйл явцыг зургаар баримтжуулан тайлагнасан.



Зураг 9. Ариутгал хийж буй байдал



Зураг 10. Байршуулсан байдал

3 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭ

Хүснэгт 7. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ

дд	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжилтийн тайлбар
1	Төслийн нөлөөлөлд өртөж буй айл өрхийн иргэд	Айл өрхийн иргэдэд олгох нэг удаагийн нөхөх олговрыг олгох	Төслийн нөлөөлөлд өртөж буй иргэдэд олгох нэг удаагийн нөхөн төлбөрийг олгох ажлын хүрээнд: а/Увс аймагт 518 иргэний үлдэгдэл санхүүжилт 3,938,145,454.0 төгрөг 2024 оны 06 сарын 21-нд шилжсэн б/ Баян-Өлгий аймаг, Увс аймаг иргэдийг тулган баталгаажуулах ажлын хийж гүйцэтгэн Баян-Өлгий аймагт 723 иргэнээс 658 иргэнд нөхөн олговор болох 7,891,117,800.0 төгрөгийн санхүүжилт 2024 оны 09 сард бүрэн олгогдсон байна.

4 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 8. ОХШХөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Гүйцэтгэлийн тайлбар
1. Агаарын чанар 2. Усны чанар 3. Хөрсөн бүрхэвч 4. Ургамлан нөмрөг 5. Амьтны аймаг	Нийт талбайн хэмжээнд	Төслийн “Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр”-ийн ажлын хүрээнд 2024.09.03 өдөр “Текол” ХХК-тай гэрээ байгуулан, судалгааны ажлын тайланг 2024.10.03-ны өдөр хүлээн авсан. Бүлэг 4.-т товч дурдав.
Нийт ОХШХ-т тусгагдсан зардал		20,000,000.0 төгрөг

4.1 Агаарын чанар

Тус мониторингийн ажлаар төслийн талбай дахь агаарын тоос, тоосонцор, дуу чимээ, түгээмэл бохирдуулагч бодисын агууламж нь MNS 4585:2016 стандартад нийцэж буй эсэх, агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, харьцуулсан шинжилгээ хийх, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулахад оршино.

Хүснэгт 9. Агаарын чанарын мониторинг судалгаанд ашиглагдсан багаж төхөөрөмж

С.Е.М. DT- 8820	
	Гадаад орчны дуу чимээг С.Е.М. DT- 8820 Америк улсад үйлдвэрсэн багажаар 10 минутын турш хэмжилт хийж Монгол улсын MNS 4585:2016 стандартад заасны дагуу хэмжилт хийсэн.
Aeroqual 500	
	Гадаад орчны агаарын чанарыг Aeroqual 500 Шинэ зеланд улсад үйлдвэрлэсэн багажаар 30 минутын турш хэмжилт хийж. Монгол улсын MNS 4585:2016 стандартад заасны дагуу хэмжилт хийсэн.

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хяналт шинжилгээний хөтөлбөрт дараах газруудад хэмжилт хийх ажлыг тусгасан. Үүнд (Бомт баригдах хэсэгт, станц баригдах талбай орчим, ажилчдын кемп орчимд, ашиглагдаж буй түр зам, болон хөрсний овоолго гэх мэт) Эдгээр газрууд нь тэгшилж бэлтгэсэн сайжруулсан зам талбайтай байх ба агаар бохирдуулагч бодисын ямар нэгэн эх үүсвэр байхгүй. Тус газруудад нь хоорондоо 0.3 км – 4 км тус тус зайд байрлана. Тухай сонгосон газрууд нь цаашид бүтээн байгуулалт хийгдэх газрууд учир агаарын чанарын мониторингийн цэгүүдээр сонгосон.



Зураг 11. Агаарын чанарын мониторингийн цэгүүд



Зураг 12. Дуу шуугианы хэмжилтийн цэгүүд

Тайлбар: Агаар дахь тоос, тоосонцрын хэмжилтийг нарийн ширхэглэгт тоосонцор (PM_{2.5}), том ширхэглэгт тоосонцор (PM₁₀), агаарын чийгшил, температур гэсэн үзүүлэлтээр Шинэ Зеланд улсад үйлдвэрлэсэн Aeroqual 500 багажаар, дуу чимээг С.Е.М. DT- 8820 Америк улсад үйлдвэрлэсэн багажаар 10 минутын турш хэмжилт хийж үр дүнг “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4585:2016” стандартын утгатай харьцуулж агаарын чанарын индекс (АЧИ)-ээр үнэлэв.

2024 оны 9-р сарын агаарын чанарын хэмжилтийн дүнгээр төслийн талбайд Монгол улсын агаарын чанарын стандарт болох MNS 4585:2016 стандартыг давсан агаар дахь бохирдуулагч бодис байхгүй, төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага гэж үзэж байна. Агаар дахь том ширхэглэгт тоосонцор 1-6 мкг/м³-ийн хооронд, нарийн ширхэглэгт тоосонцор 1-2 мкг/м³-ийн хооронд буюу зөвшөөрөгдөх хэмжээнээс хэд дахин бага үзүүлэлттэй байна. Хэмжилт хийсэн бүх цэгүүдэд орчны дуу шуугианы төвшин хэвийн байна.

4.1.1 Орчны дуу шуугиан

Агаарын бохирдуулагч бодис хэмжсэн цэгүүдэд орчны дуу шуугианы хэмжилтийг өдрийн цагаар хийж гүйцэтгэсэн. Манай улсын агаарын чанарын стандарт өдөр (07-22 цаг), шөнө (22-07 цаг)-ийн шуугианы түвшний зөвшөөрөгдөх хэмжээг журамласан байдаг. Хэмжилтийн дүн нь өдрийн цагийн дундаж шуугианы түвшнийг илэрхийлэх ба хэрэв энэ хэмжээ хоногийн турш хадгалагдана гэж үзвэл бомт болон станц баригдах талбай орчим шуугианы төвшин өдөр, шөнийн цагаар гадаад орчны шуугианы зөвшөөрөгдөх төвшнөөс давж болзошгүй байна.




Зураг 13. Дуу шуугианы хэмжилтийн цэгүүд

4.1.2 Дүгнэлт

- Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслийн агаарын чанарын хяналт шинжилгээний дүнгээр төслийн талбайд Монгол улсын агаарын чанарын стандарт болох MNS 4585:2016 стандартыг давсан агаар дахь бохирдуулагч бодис байхгүй, төслийн барилгын ажилын үед агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл дунд гэж үзэж байна.
- Хэмжилтийн үр дүнгээс харахад агаар дахь том ширхэглэгт тоосонцор $1-6 \text{ мкг/м}^3$ -ийн хооронд, нарийн ширхэглэгт тоосонцор $1-2 \text{ мкг/м}^3$ -ийн хооронд, нүүрстөрөгчийн дутуу исэл нь $723-1116 \text{ мкг/м}^3$, Азотын давхар исэл нь $0-0.021 \text{ мкг/м}^3$ буюу зөвшөөрөгдөх хэмжээнээс хэд дахин бага үзүүлэлттэй байна.
- Орчны дуу шуугианы төвшин төслийн барилгын ажлын өмнөх үед барилга байгууламж барих газруудын орчимд зөвшөөрөгдөх хэмжээнээс бага байна.

4.2 Усан орчин

“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл” хэрэгжих талбайн орчим дахь уст цэгүүдээс дээж авч 2024 оны усан орчны мониторинг судалгааг гүйцэтгэж, MNS 0900:2016, MNS 6148:2010, MNS 4586:1998 стандартууд болон өмнөх мониторинг судалгааны үр дүнтэй харьцуулж, уг төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж буй нөлөөлөл бий эсэхийг тогтоох зорилготой.



Зураг 14. Усны дээж авсан цэгийн байршил

Ажилчдын кемп, гүний худаг: 2024 оны 9 сарын лабораторийн задлан шинжилгээний дүнгээр “Ажилчдын кемп, гүний худаг” ус нь химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд нэн цэнгэг, маш зөөлөн ус, шинжилсэн химийн үзүүлэлтүүдээс нь “Ундны усны стандарт MNS 0900:2018” стандартын шаардлага хангаж байгаа тул унданд хэрэглэх тохиромжтой.

Ховд гол, дээд хэсэг: 2024 оны 9 сарын лабораторийн задлан шинжилгээний дүнгээр “Ховд гол, дээд хэсэг” ус нь химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд нэн цэнгэг, маш зөөлөн ус, шинжилсэн химийн үзүүлэлтүүдээс нь “Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 4586:1998” стандартын шаардлага хангаж байгаа тул унданд хэрэглэх тохиромжтой.

Ховд гол, доод хэсэг: 2024 оны 9 сарын лабораторийн задлан шинжилгээний дүнгээр “Ховд гол доод хэсэг” ус нь химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд нэн цэнгэг, маш зөөлөн ус, шинжилсэн химийн үзүүлэлтүүдээс нь “Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 4586:1998” стандартын шаардлага хангаж байгаа тул унданд хэрэглэх тохиромжтой.

4.2.1 Дүгнэлт


- Усны мониторинг судалгааг төслийн талбайн байрлах Ховд гол, Ажилчдын кемп дээр гаргасан гүний худаг нийт 3 цэгээс дээж авч, лабораторийн задлан шинжилгээ хийлгэв.
- 2020 оны лабораторийн задлан шинжилгээний үр дүнтэй харьцуулахад ерөнхий химийн үзүүлэлтүүдийн агууламж буурсан, зөвшөөрөгдөх хэмжээнээс даваагүй бөгөөд MNS 4586:1998 стандартын шаардлага хангасан байна.
- Тус 2020 он, 2024 онд Ховд голоос авсан дээжийн үр дүгээс харахад усны дээж авсан уст цэг бүрийн үзүүлэлтүүдийн агууламж буурсан, усны чанар дээшилсэн буюу төслийн үйл ажиллагаанаас газар доорх усны чанарт сөрөг нөлөөлөл үзүүлээгүй байна.
- Төслийн ажилчдын ундны зориулалтаар хэрэглэдэг гүний худгийн ус нь химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд

нэн цэнгэг, маш зөөлөн ус байна. Шинжилсэн химийн үндсэн үзүүлэлтүүд нь “Ундны усны стандарт MNS 900:2018” стандартын шаардлага хангаж байна.

- Ажилчдын кемп дээр гаргасан гүний худгийн усыг унд ахуйн хэрэглээнд шууд ашиглаж хэрэглэх боломжтой.
- Цаашид ажилчдын кемп байрлах гүний худагт мониторинг судалгааг үргэлжлүүлэн хийх шаардлагатай гэж үзсэн байна.

4.3 Хөрсөн бүрхэвч

Судалгаанд Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Ховд аймгийн Мянгад, Увс аймгийн Өмнөговь, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын нутагт 28000 га талбай хамрагдсан болно. Талбай дээр хөрсний зүсэлт морфологи бичиглэл хийж, дээж авах ажлыг гүйцэтгэсэн. Төслийн талбайн хөрсний үндсэн шинжийг тодорхойлох, хөрсний хими, физик шинж чанарын ерөнхий үзүүлэлтүүдийг “Инженер Геодези” ХХК-ний итгэмжлэгдсэн лабораторид тодорхойлуулж, задлан шинжилгээ хийлгэж дүнг хавсаргасан болно.



Зураг 15. Төслийн талбай орчмын хөрсний тархалт, зүсэлт хийж дээж авсан цэгүүдийн байршил

Хөрсний хээрийн судалгааны үед нийт 14 хөрсний дээж авсан бөгөөд боомт, станц, ажилчдын кемп гэсэн 3 байршил дээр хөрсний зүсэлт хийгдсэн. Айлын өвөлжөө хаваржаа, шимт хөрсний овоолго гэх байршлуудаас өнгө хөрсний дээж авсан. Ажилчдын кемпийн авто машины зосоол, цэвэрлэх байгууламжийн орчмоос өнгө хөрсний дээж авч бохирдлын дээж авсан.

4.3.1 Дүгнэлт


- Хөрсний морфологи тогтцын бичлэг лабораторийн шинжилгээний дүнгээс үзэхэд Аллювийн нугын хөрс (3206), нь хөрс сул шүлтлэг урвалын орчинтой байна. Хөрсний биологийн

идэвхи, ургамлын өсөлт хөгжилтөд таатай юм. Хөрс 0-10 см үедээ 0.14-0.3 хувийн ялзмагтай байна. 10 см-ээс доош ялзмаг агуулалт эрс буурч байна.


- Төслийн талбайд хийсэн 9-р сарын судалгааны химийн задлан шинжилгээний үр дүнгээс авч үзвэл хөрсний үржил шимийн гол үзүүлэлт болох ялзмагийн хэмжээ төслийн талбай түүний орчмын хөрсөнд 0.14-0.91% хооронд хэлбэлзэж байна. Хөрсөнд агуулагдах давсны хэмжээг тодорхойлох ЕС (хөрсний цахилгаан дамжуулах чадвар)-ийн хэмжээ 0.0424-0.14 dS/m хооронд хэлбэлзэнэ. Өөрөөр хэлбэл, 1 dS/m-ээс доош агууламжтай хөрсийг давсгүй гэж үзнэ. Урвалын орчин төслийн талбайн хөрсөнд 8.45-8.76 хооронд хэлбэлзэж байна. Нийт талбайн хэмжээгээр авч үзвэл урвалын орчин дунджаар хэмжээ нь 8.668 буюу хүчтэй шүтлэг түвшинд байна. Ургамлын хүнс тэжээлд шууд хэрэглэгдэх хөдөлгөөнт фосфорын хэмжээ харьцангуй бага түвшинд буюу 100 гр хөрсөнд 0.4-2.5 мг хооронд хэлбэлзэнэ. Мөн түүнчлэн 100 гр хөрсөнд байх хөдөлгөөнт калийн хэмжээ багавтар түвшинд буюу 11-49 мг-ийн хооронд хэлбэлзэнэ. Ургамлын ургалтад зайлшгүй шаардлагатай дагалдах элемент Са хэмжээ 4.5-12.6 мг-экв/100 гр, харин Mg хэмжээ 2.2-10.8 мг-экв/100 гр хооронд тус тус хэлбэлзэнэ.
- Хөрсний физик шинжилгээний үр дүнг хүснэгт 17-т үзүүлэв. Хөрсний дээжийг ширхгийн бүрэлдэхүүнээр элс, тоос, шаврын харьцаагаар тодорхойлоход том ширхэгтэй элсэн фракцын хэмжээ 25.4-53.6%, жижиг ширхэгтэй элсэн фракцын хэмжээ 0.6-7% хооронд хэлбэлзэж байна. Харин тоосон фракцын нийлбэр 1.6-5.2% хооронд, шавар фракцын хэмжээ 6.2-16.2%-ийн хооронд тус тус хэлбэлзэнэ. Дээрх үр дүнгээс харахад төслийн талбайн бүх хөрсөнд элсний агууламж дийлэнх хувийг эзэлж, түүний дараа тоос, шаврын агууламж багахан хувийг бүрдүүлж байна.
- “Инженер геодези” ХХК-ний итгэмжлэгдсэн лабораторийн задлан шинжилгээний дүнгээр дээрх 4 төрлийн үзүүлэлт бүх дээжний хувьд E.Coli, Salmonella, Cl.perfringens, нянгийн нийт тоо хэмжээ 3MNS 6341:2012, MNS 5367:2004, MNS3297:2019” стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага буюу бохирдол үүсээгүй байгааг илтгэнэ. Ажилчдын кемпийн цэвэрлэх байгууламжийн нянгийн тоо Увс аймгийн Өмнөговь сумын Улиаст багийн айлуудын өвөлжөө, хаваржаанууд нянгийн нийт тоо эрс бага байна.
- “Инженер геодези” ХХК-ний итгэмжлэгдсэн лабораторийн задлан шинжилгээний дүнгээр хөрсөнд агуулагдах хүнд металлын агууламж бүх дээжний хувьд “Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019” стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага буюу бохирдолгүй түвшинд байна.
- Мөн хөрсний үе давхаргуудад элсний агууламж давамгайлах учраас салхи, усны элэгдэлд өртөх эрсдэл өндөр байдаг бөгөөд цаашид элэгдэл, эвдрэлд орох талбай нэмэгдэх хандлагатай байна.

4.4 Ургамлан нөмрөг

Төслийн үйл ажиллагааны явцад ургамлан нөмрөгт үзүүлэх өөрчлөлт, доройтол ажиглагдаж байгаа эсэх, мөн ургамлан нөмрөгт сөрөг нөлөө үзүүлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, харьцуулсан судалгаа хийх, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулахад оршино.



Зураг 16. Ургамал газарзүйн мужлалт



Зураг 17. 2020-2024 оны ургамалжилтын зураг

4.4.1 Дүгнэлт

- “Эрдэнэбүрэн усан цахилгаан станцын төсөл”-ийн талбайд ургамлан нөмрөгийн хээрийн судалгааг 2024 оны 09 дугаар сарын 09-10-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн. Тухайн ландшафтаас хамааран Дундаж өндөр болон нам, бэсрэг уулын Харгана-үетэнт Сөөг – үетэнт, Монгол өвст, Харгана- хялганат, Голын хөндийн Улалж-алаг өвст, Жижиг улалж-алаг өвст, Холимог сөөгт, Цөлөрхөг хээрийн Харганат бүлгэмдлүүд тархсан байна.
- Төслийн талбай орчмын бүс нутагт хээрийн болон цөлөрхөг хээрийн ургамалжилт давамгайлан тархсан бөгөөд цөлөрхөг хээрт сөөг, сөөгөнцөр ургамлын бүлгэмдэлд үзүүлэх үүрэг эрс өсдөг. Ургамлын бүрхэц нийт талбайн хэмжээнд дунджаар 40-45 хувийн бүрхэцтэй, дундаж өндөр--сөөг болон сөөгөнцөр ургамлын 60-65, олон наст үет ургамал 10-15 см, алаг өвс болон нэг наст ургамал 8-10 см өндөр ургасан байна.
- Төслийн талбайд хийсэн хээрийн судалгааны явцад 12 овгийн, 23 төрөлд багтах, 29 зүйл ургамлыг бүртгэн тэмдэглэсэн. Одоогийн байдлаар бүлгэмдлийн ургацын биомасс дунджаар 3.2 цн/га байна. Байгалийн өвөрмөц тогтоц, Байгалийн ургамлын тухай хуулийн

хавсралт, Монгол Улсын улаан ном зэрэгт бүртгэгдсэн ургамал тааралдаагүй хэдий ч төслийн талбайд (өнөөгийн байдлаар) бэлчээр, тэжээлийн үнэт ургамал *Caragana-Hаргана*, *Stipa gobica*-Говийн хялгана, *Agropyron cristatum*-Саман ерхөг, *Eurotia ceratoides*-Орог тэсэг, *Achnatherum splendens*-Гялгар дэрс зэрэг зүйлүүд тэмдэглэгдсэн.

- Хээрийн судалгаа болон боловсруулалтын явцад бүлгэмдлийн зонхилогч, дэд зонхилогч, ерөнхий тусгаг бүрхэц, халцгай газар, хүмүүнсэг ургамлын эзлэх хувь хэмжээг харгалзан үзэж ургамлан нөмрөгийн талхагдлыг тодорхойлох MNS 5546:2005 стандартын ангиллын дагуу тодорхойлон Хэвийн соргог болон Сул доройтсон ангилалд хамруулав. Баруун бүс нутгийн иргэдийн аж амьдрал, уур амьсгалын онцлогоос хамааран нутгийн малчин өрхүүдийн 90-95 хувь нь Ховд голын хөндийд байрлаж мал аж ахуй эрхэлж байна.

4.5 Амьтны аймаг

Төслийн ашиглалтын үеийн зэрлэг амьтны мониторинг хийх, төслийн талбайн зэрлэг амьтны судалгааны талаар дүгнэлт гаргаж, өмнөх мониторинг судалгааны үр дүнтэй харьцуулах, зорилготой.



Зураг 18. Усны шувууд



4.5.1 Дүгнэлт

Барилгын ажлын үе шатанд Төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнөх орчны сөрөг нөлөөллийг тогтоосноор амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, хамгаалах ажлыг оновчтой төлөвлөх хэрэгтэй юм.

- Төсөл хэрэгжих орчны амьтны аймагт барилгын ажил, газрын усанд авталт зэрэг амьдрах орчных нь өөрчлөлтүүдээс хамаарч дараах сөрөг нөлөөллүүд гарахаар байна.
- Хөхтөн амьтад болон загас, мөлхөгчид, усны хөвөгч ба ёроолын амьтдын хувьд нүүдэллэн шилжих талбай нь хуваагдаж багасах.
- Зарим бургас бутны төгөлд амьдардаг амьтдын амьдрах орчин хомсдох
- Хүн ба техникийн хөдөлгөөн болон дуу чимээнээс зэрлэг амьтад дайжих
- Барилгын газар шорооны ажил, ачаа тээвэрлэлтийн болон усан сангийн дүүргэлтийн явцад мөлхөгчид, шавж, огдойн төрлийн амьтад өртөж устах зэрэг болно.

5 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ

Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг хүснэгтээр үзүүлэв.


Хүснэгт 10. Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

ДД	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжилтийн тайлбар
1.	Тухайн жилийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г өмнөх оны 12-р сард багтаан БОАЖЯ-аар батлуулж, 3 аймгаар дүгнүүлэх ажлыг зохион байгуулах хүрээнд бэлтгэл хангах	Төслийн Байгаль орчны менежментийн 2024 оны төлөвлөгөөг батлуулахтай холбоотой дараах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн. Үүнд: ✓ 2024 оны БОМТ, хийгдэх арга хэмжээнүүдтэй уялдсан зардлын төсвийг Эрчим хүчний сайдаар батлуулсан. ✓ 2024 оны 02 дугаар сарын 01 өдрийн ТУХ-ны хуралд 2024 оны БОМТ-г танилцуулан, гишүүдийн санал зөвлөмжийг тусган БОАЖЯ-аар батлуулахаар дэмжигдсэн. ✓ 2024 оны БОМТ-г ТУХ-ны зөвлөмжийн хамт 2024 оны 04 сарын 02-ны өдөр БОАЖЯ-ны сайтад цахимаар илгээсэн. ✓ 2024 оны БОМТ-г 04 сарын 15-ны өдөр БОАЖЯ батлуулсан. ✓ ЭХС-ын багцад тусгагдсан төсвийн хүрээнд БОМТ-ыг хэрэгжүүлэх зардлын төсвийг ЭХС-ын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дугаар А/78 тоот тушаал, 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн дугаар А/223 тоот тушаалуудаар батлуулсан болно. ✓ БНХАУ-ын ЭКСИМ банктай байгуулах “Тусгайлсан зээлийн хэлэлцээр” 2024 оны 11 сард хийгдсэн учир барилга байгууламжийн бүтээн байгуулалтын ажил 2025 онд эхлэхээр төлөвлөгдөж байна.

6 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ

дд	Арга хэмжээ	Тайлбар
1.	БОМТ-ний биелэлтийг тайлагнах цахимд байршуулах	Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийг дүгнүүлэх зорилгоор:
	Ховд, Увс, Баян-Өлгий аймгийн Байгаль орчны газраар биелэлтийн тайланг дүгнүүлэх	✓ Увс, Ховд, Баян-Өлгий аймгуудын Байгаль орчин, аялал жуулчлалын газруудад хүсэлт гарган, ажлын хэсэгт биелэлтийг танилцуулсан. ✓ Орон нутгийн зүгээс санал, зөвлөмжийг хүлээн авсан.
	БОАЖЯ-аар Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулах	✓ Цахим системд биелэлтийн тайланг байршуулсан. ✓ Мөн “Тусгайлсан зээлийн хэлэлцээр”-тэй холбоотой шалтгааны улмаас төслийн талбайд барилга байгууламжийн ажил хийгдээгүй тул 2024 оны БОМТ-д тусгагдсан зарим арга хэмжээний төлөвлөгөөг 2025 онд хийж хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. ✓ Увс, Ховд, Баян-Өлгий аймгуудын Байгаль орчин, аялал жуулчлалын газрууд биелэлтийн тайланг дүгнэснээр БОУАӨЯ-аар 2025 оны төлөвлөгөөг батлуулна.

Төслийн 2024 оны БОМТ-ний биелэлтийн тайланг боловсруулж, Увс, Ховд, Баян-Өлгий аймгуудын Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ажлын хэсэгт танилцуулга хийсэн. Тус ажлын хэсэгт “Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ”-ний бэлтгэл ажлын хүрээнд гүйцэтгүүлсэн суурь судалгааны ажлуудыг багтаан танилцуулж, ажлын хэсгээс гаргасан санал, зөвлөмжийг 2025 оны төлөвлөгөөнд багтаан, орон нутагтай хамтарч ажиллахаар төлөвлөж байна.



Зураг 19. Увс аймгийн БОАЖГазар



Зураг 20. Ховд аймгийн БОАЖГазар



Зураг 21. Баян-Өлгий аймгийн БОАЖГазар

ХАВСРАЛТ



МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 10 сарын 16 өдөр

Дугаар А/223

Улаанбаатар хот

Тушаалын шинэчлэн батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2.3, “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл”-ийн Төслийн удирдах хорооны 2024 оны 3 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.”Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл”-ийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлын төсвийг нэгдүгээр хавсралтаар, нөлөөлөлд хамаарах айл өрхийн иргэн бүрд олгох нэг удаагийн нөхөн төлбөрийн зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Эрчим хүчний сайдын 2024 оны урсгал зардлын төсвийн “Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж” ангиллаас нэгдүгээр хавсралтаар батлагдсан төсвийг, “Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал” ангиллаас хоёрдугаар хавсралтаар батлагдсан төсвийг санхүүжүүлэхийг Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга (О.Хуягцогт)-д даалгасугай.


3.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Н.Тавинбэх)-д даалгасугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрчим хүчний сайдын 2024 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн А/78 дугаар тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.



Б.ЧОЙЖИЛСҮРЭН

170600000532



“ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ ТӨСӨЛ”-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
2024 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын үзүүлэлт	Эхлэх	Дуусах	БОМТ-ний зардлын төсөв	2024 онд санхүүжих дүн
1	Нүүлгэн шилжүүлэх, Эд хөрөнгийн нөхөн олговрын төлөвлөгөөний зардал	2022	2024	5,302.3	212.7
1.1	Баян-Өлгий аймаг	2022	2024	4,501.7	154.9
1.2	Увс аймаг	2022	2024	800.6	57.8
2	Түүх, соёлын өвийг авран хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний зардал	2022	2025	2,027.5	660.0
2.1	Соёлын биет бус өв угсаатны зүйн авран хамгаалах тандалт судалгааны ажил	2022	2025	1,427.5	60.0
2.2	Казах иргэдийн булш, бунхан нүүлгэн шилжүүлэх ажил	2022	2024	600.0	600.0
3	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал	2022	2024	433.6	154.2
3.1	Төслийн бэлтгэл болон барилгын ажлын үе шатанд үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	2022	2024	378.4	99.0
3.2	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2022	2024	20.0	20.0
3.3	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	2022	2024	35.2	35.2
Нийт дүн				7,763.4	1,026.9

Эрчим хүчний сайдын 2024 оны
... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

“ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ ТӨСӨЛ”-ИЙН НӨЛӨӨЛӨЛД ХАМААРАХ АЙЛ ӨРХИЙН
ИРГЭН БҮРД ОЛГОХ НЭГ УДААГИЙН НӨХӨН ТӨЛБӨРИЙН 2024 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

/сая.төг/

№	Зардлын үзүүлэлт	Эхлэх	Дуусах	Зардлын төсөв	2024 онд санхүүжих дүн
1	Нүүлгэн шилжүүлэх, Нэг удаагийн нөхөн төлбөр	2022	2024	19,353.6	12,257.4
1.1	Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын 723 иргэн	2022	2024	10,931.8	8,289.0
1.2	Увс аймгийн Өмнөговь сумын 518 иргэн	2022	2024	7,832.2	3,938.1
1.3	Ховд аймаг Эрдэнэбүрэн сум 37 иргэн	2022	2024	589.7	30.2
Нийт дүн				19,353.6	12,257.4

---oOo---

БАТЛАВ:
“ҮРЖИЛ ШИМТ СҮРЭГ” ХХК-НИЙ
ЗАХИРАЛ



БАТЛАВ:
“ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН
СТАНЦ ТӨСӨЛ”-ИЙН ЗОХИЦУУЛАГЧ



ТӨСЛИЙН ТАЛБАЙ ДАХЬ ОЙ МОДНЫ НАРИЙВЧИЛСАН СУДАЛГАА ХИЙХ АЖЛЫН ГЭРЭЭ

2024 оны 10 сарын 08 өдөр

Дугаар АЧГ-2024/111

Улаанбаатар хот

Нэг. Гэрээний үндэслэл

Ховд, Увс, Баян-Өлгий аймаг, Эрдэнэбүрэн, Мянгад, Өмнөговь, Баяннуур сумын нутагт байрших Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөлд Монгол Улсын "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулийг баримтлан нэг талаас "Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл" ТХН (цаашид Захиалагч гэх), нөгөө талаас "Үржил шимт сүрэг" ХХК (цаашид Гүйцэтгэгч гэх) хооронд Захиалагчийн хүсэлтийн дагуу төслийн талбай дахь ой модны нарийвчилсан судалгааг хийхээр энэхүү гэрээг байгуулав.

Гэрээлэгч талууд:

Захиалагч: Нэр: "Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл" ТХН
Хаяг: УБ хот, ХУД, 19-р хороо, Богд Жавзандамба хутагтын гудамж,
"Тайж оффис" групп, 201
Утас: 77551516
Цахим шуудан: info@erdeneburenhpp.mn
Регистрийн дугаар: 9922431

Гүйцэтгэгч: "Үржил шимт сүрэг" ХХК
Хаяг: Ховд аймаг, Жаргалант сум, Жаргалан баг, 2-80 айл 26 тоот
Утас: 99437114
Регистрийн дугаар: 4085612

Хоёр. Гэрээний ерөнхий зүйл

- 2.1. Ажлын зорилго: Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслийн нуур үүсэхээс өмнө шимт хөрсийг нөхөн сэргээлт хийхэд зориулан бэлтгэх, нөхөн сэргээлтийн усалгаанд тохирсон системийг цогцоор нь шийдвэрлэсэн зураг төслийн ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх /Мод үржүүлэг, Хүлэмжийн аж ахуйн газар/ ажлын хүрээнд төслийн талбай дахь ой модны нарийвчилсан судалгааны ажлын тайлан нь Монгол Улсын болон олон улсын стандарт норм, арга зүйн шаардлагыг хангана.
- 2.2. Судалгааны ажлын тайлан нь эх хэл дээр хийгдэнэ. Тухайн ажлын тайланг гадаад хэл рүү хөрвүүлэх бол орчуулгын хөлсийг хоёр тал нэмж харилцан тохиролцоно.
- 2.3. Энэхүү гэрээ нь Гүйцэтгэгч болон Захиалагч талууд хамтран баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 2.4. Гүйцэтгэгч, Захиалагч талуудын хооронд солилцсон материал нь гуравдагч этгээдэд нууц байна.
- 2.5. Захиалагч нь гэрээнд дурдсан төлбөрийг бүрэн барагдуулсны дараа судалгааны ажлын тайланг эзэмших эрх эдэлнэ.
- 2.6. Гэрээт ажлын нийт үнэ: 13 500 000 ₮ (арван гурван сая таван зуун мянган төгрөг) байна.

Гэрээ байгуулсан:


Гүйцэтгэгч талыг төлөөлж:

“Үржил шимт сүрэг” ХХК-ний ойн инженер
У.Цэцгээ


.....

Захиалагч талыг төлөөлж:


“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц
төсөл”-ийн Ерөнхий инженер
Ж.Лувсандандар


.....

БАТЛАВ:
“ХОС НАХИА” ХХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ



БАТЛАВ:
“ЭРДЭНЭБҮРЭНГИЙН
ЦАХИЛГААН СТАНЦ ТӨСӨЛ”-ИЙН
ЗОХИЦУУЛАГЧ



**ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ ТӨСЛИЙН ТАЛБАЙН ХӨРСНИЙ
МИКРОБИОЛОГИЙН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ
ХИЙХ АЖЛЫН ГЭРЭЭ**

2024 оны 10 сарын 10 өдөр

Дугаар АЧГ-2024/112

Улаанбаатар хот

Нэг. Гэрээний үндэслэл

Ховд, Увс, Баян-Өлгий аймаг, Эрдэнэбүрэн, Мянгад, Өмнөговь, Баяннуур сумын нутагт байрших Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөлд Монгол Улсын "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулийг баримтлан нэг талаас “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл” ТХН (цаашид Захиалагч гэх), нөгөө талаас “Хос нахиа” ХХК (цаашид Гүйцэтгэгч гэх) хооронд Захиалагчийн хүсэлтийн дагуу төслийн талбай дахь хөрсний микробиологийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэхээр энэхүү гэрээг байгуулав.

Гэрээлэгч талууд:

Захиалагч: Нэр: “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл” ТХН
Хаяг: УБ хот, ХУД, 19-р хороо, Богд Жавзандамба хутагтын гудамж,
“Тайж оффис” групп, 201
Утас: 77551516
Цахим шуудан: info@erdeneburenhpp.mn
Регистрийн дугаар: 9922431

Гүйцэтгэгч: Нэр: “Хос нахиа” ХХК
Хаяг: УБ хот, ЧД, 5-р хороо, MN tower, 12 давхар, 1201 тоот
Утас: 93393035, 90963535
Цахим шуудан: khosnakhiallc@gmail.com
Регистрийн дугаар: 6407447


Хоёр. Гэрээний ерөнхий зүйл

- 2.1. Ажлын зорилго: Төслийн нөлөөлөлд өртөж буй Увс аймгийн Өмнөговь сумын 125 айл өрх, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын 145 айл өрхийн нүүлгэн шилжүүлэлтээс үүсэх хөрсний гадаргын микробиологийн бохирдлын түвшин усан сан үүсгэн усыг хуримтлуулахад сөрөг нөлөө үзүүлэх эсэхийг тодорхойлох судалгааны ажлын тайлан нь Монгол Улсын болон олон улсын стандарт норм, арга зүйн шаардлагыг хангана.
- 2.2. Судалгааны ажлын тайлан нь эх хэл дээр хийгдэнэ. Тухайн ажлын тайланг гадаад хэл рүү хөрвүүлэх бол орчуулгын хөлсийг хоёр тал нэмж харилцан тохиролцоно.
- 2.3. Энэхүү гэрээ нь Гүйцэтгэгч болон Захиалагч талууд хамтран баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 2.4. Гүйцэтгэгч, Захиалагч талуудын хооронд солилцсон материал нь гуравдагч этгээдэд нууц байна.
- 2.5. Захиалагч нь гэрээнд дурдсан төлбөрийг бүрэн барагдуулсны дараа судалгааны ажлын тайланг эзэмших эрх эдэлнэ.
- 2.6. Гэрээт ажлын нийт үнэ: 46,740,000 ₮ (дөчин зургаан сая долоон зуун дөчин мянган төгрөг) байна.

Гэрээ байгуулсан:

Гүйцэтгэгч талыг төлөөлж:


“Хос нахиа” ХХК-ний Ерөнхий менежер
Э.Баасансүх



.....

Захиалагч талыг төлөөлж:

“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц
төсөл”-ийн Ерөнхий инженер
Ж.Лувсандандар




.....

БАТЛАВ:
“МОНГОЛЫН БАЙГАЛЬ
ХАМГААЛАГЧДЫН ХОЛБОО” ТББ-
ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ


...../С.БАЯРХҮҮ/

БАТЛАВ:
“ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН
СТАНЦ ТӨСӨЛ”-ИЙН ЗОХИЦУУЛАГЧ


...../Ч.САРАНЖАВ/


**ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ХӨХТӨН АМЬТДАД НӨЛӨӨЛӨХ НӨЛӨӨЛЛИЙН СУДАЛГААНЫ
ХИЙХ АЖЛЫН ГЭРЭЭ**

2024 оны 10 сарын 10 өдөр

Дугаар АЧГ-2024/113

Улаанбаатар хот

Нэг. Гэрээний үндэслэл

Ховд, Увс, Баян-Өлгий аймаг, Эрдэнэбүрэн, Мянгад, Өмнөговь, Баяннуур сумын нутагт байрших Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөлд Монгол Улсын "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулийг баримтлан нэг талаас “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл” ТХН (цаашид Захиалагч гэх), нөгөө талаас “Монголын байгаль хамгаалагчдын холбоо” ТББ (цаашид Гүйцэтгэгч гэх) хооронд Захиалагчийн хүсэлтийн дагуу төслийн талбай дахь сээр нуруутан амьтдын судалгааны ажлыг хийж гүйцэтгэхээр энэхүү гэрээг байгуулав.

Гэрээлэгч талууд:

Захиалагч: Нэр: “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл” ТХН
Хаяг: УБ хот, ХУД, 19-р хороо, Богд Жавзандамба хутагтын гудамж,
“Тайж оффис” групп, 201
Утас: 77551516
Цахим шуудан: info@erdeneburenhpp.mn
Регистрийн дугаар: 9922431

Гүйцэтгэгч: Нэр: “Монголын байгаль хамгаалагчдын холбоо” ТББ
Хаяг: Хан-Уул дүүрэг Цэнгэг ус байгаль хамгаалах төв 307 тоот
Утас: 99049896
Цахим шуудан: rangerfederation@gmail.com
Регистрийн дугаар: 8276412

Хоёр. Гэрээний ерөнхий зүйл

- 2.1. Ажлын зорилго: Улсын тусгай хэрэгцээний 28000 га талбай тэр дундаа төслийн нөлөөлөлд өртөх станцын барилга баригдах 117 га, нуур үүсэх 9871.1 га талбайд тухайн орчин дахь сээр нуруутан амьтдын амьдрах орчин, тэдгээрийн тоо толгой, тархац нутгийг тодорхойлох; станцын барилгын бүтээн байгуулалтын үйл ажиллагаа амьтдын амьдрах орчинд хэрхэн нөлөөлөхийг тогтоох судалгааны ажлын тайлан нь Монгол Улсын болон олон улсын стандарт норм, арга зүйн шаардлагыг хангана.
- 2.2. Судалгааны ажлын тайлан нь эх хэл дээр хийгдэнэ. Тухайн ажлын тайланг гадаад хэл рүү хөрвүүлэх бол орчуулгын хөлсийг хоёр тал нэмж харилцан тохиролцоно.
- 2.3. Энэхүү гэрээ нь Гүйцэтгэгч болон Захиалагч талууд хамтран баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 2.4. Гүйцэтгэгч, Захиалагч талуудын хооронд солилцсон материал нь гуравдагч этгээдэд нууц байна.
- 2.5. Захиалагч нь гэрээнд дурдсан төлбөрийг бүрэн барагдуулсны дараа судалгааны ажлын тайланг эзэмших эрх эдэлнэ.



- 7.3. Гэрээг 3 хувь үйлдэж, хувь тус бүрийг хоёр тал хадгалах ба хуулийн өмнө адил хүчин төгөлдөр байна.

Гэрээ байгуулсан:

Гүйцэтгэгч талыг төлөөлж:

“Монголын байгаль хамгаалагчдын холбоо”
ТББ-ын судлаач М.Дагвасүрэн


.....

Захиалагч талыг төлөөлж:

“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц
төсөл”-ийн Ерөнхий инженер
Ж.Лувсандандар


.....

МОНГОЛ УЛС



**“ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨСӨЛ
БОЛОН
“ШУА-ИЙН ТҮҮХ, УГСААТНЫ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН”
ХООРОНД БАЙГУУЛСАН**

**ХОВД АЙМГИЙН ЭРДЭНЭБҮРЭН, МЯНГАД, УВС АЙМГИЙН
ӨМНӨГОВЬ, БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН БАЯННУУР СУМЫН НУТГИЙГ
ДАМНАН ОРШИХ “ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ”-
ИЙН ҮНДСЭН ТАЛБАЙД УГСААТНЫ ЗҮЙН АВРАН ХАМГААЛАХ,
ТАНДАЛТ СУДАЛГАА ХИЙХ ГЭРЭЭ**


2024 оны 07 сарын 05-ний өдөр

БАТЛАВ:



“ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН
СТАНЦ” ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ

Ч.САРАНЖАВ



ГҮЙЦЭТГЭГЧ:

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН
ТҮҮХ УГСААТНЫ ЗҮЙН
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ

Ц.ЦЭРЭНДОРЖ

**ХОВД АЙМГИЙН ЭРДЭНЭБҮРЭН, МЯНГАД, УВС АЙМГИЙН ӨМНӨГОВЬ, БАЯН-
ӨЛГИЙ АЙМГИЙН БАЯННУУР СУМЫН НУТГИЙГ ДАМНАН ОРШИХ
“ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ”-ИЙН ҮНДСЭН ТАЛБАЙД
УГСААТНЫ ЗҮЙН АВРАН ХАМГААЛАХ, ТАНДАЛТ СУДАЛГАА ХИЙХ ГЭРЭЭ**

Улаанбаатар хот

№ ЭСР/АГТ/... 07 АУГ-2024/01

2024 оны 07 сарын 05-ний өдөр

Нэг талаас “ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨСЛИЙН НЭГЖ (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ТҮҮХ УГСААТНЫ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу судалгааны ажилтай холбогдсон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний зорилго оршино.

Захиалагч нь Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Мянгад, Увс аймгийн Өмнөговь, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын нутгийг дамнан орших “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц”-ийн үндсэн талбайд угсаатны зүйн авран хамгаалах, тандалт судалгаа (цаашид “ажил” гэх) хийлгэж, судалгааны ажилд шаардагдах зардлыг хариуцна

2. Захиалагч нь ажлыг **57,732,000.00 төг (тавин долоон сая долоон зуун гучин хоёр мянга)** төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

3. Гүйцэтгэгч нь Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Мянгад, Увс аймгийн Өмнөговь, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын нутгийг дамнан орших “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц”-ийн үндсэн талбайд угсаатны зүйн авран хамгаалах, тандалт судалгааны ажлыг 2024 оны 08-р сарын 12-ний өдөр эхэлж, 2024 оны 08-р сарын 25-ний өдөр дуусгаж, захиалагч талд тайланг 2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр гэхэд бүрэн хүлээлгэн өгнө.

4. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 4.1. Гэрээний тусгай нөхцөл;
- 4.2. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 4.3. Бусад шаардлагатай баримт бичиг;

Гэрээ нь дурдсан ажлыг гүйцэтгэх тухай талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу шийдвэрлэнэ.


6. Гүйцэтгэгч нь гэрээнд заасны дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн ажлыг гүйцэтгэж, зөрчил, доголдол гарсан тохиолдолд эдгээрийг арилгах үүрэг хүлээнэ.

7. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үүргийг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх болон гэрээнд заасан бусад үүргийг хүлээнэ.

8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор талуудын дараах төлөөлөгчидтэй харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц
төслийн Ерөнхий инженер


Ж.ЛҮВСАНДАНДАР

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул
дүүрэг, 19-р хороо, Тайж групп оффис, 2-р
давхар 201 тоот
Утас: 77551516
РД: 9922431

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ШУА-ын Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн
Нийгэм-соёлын хүн судлалын салбарын
эрхлэгч



Г.БЯМБАРАГЧАА

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13-р
хороо, Энхтайвны өргөн чөлөө, III. ШУ-
ны Хүрээлэнгүүдийн нэгдсэн 1-р байр.
Утас: +976 11 458305, 89118953
И-мэйл: history@mas.ac.mn
РД: 9095772
Харилцагч банкны нэр: Төрийн сан
Дансны дугаар: 100900015487 /төгрөг/

БАТЛАВ:
“КЕНЖЕДАРА ТРЕЙД” ХХК-НИЙ
ЗАХИРАЛ



...../Х.ХАНАТ/

БАТЛАВ:
“ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН
СТАНЦ ТӨСӨЛ”-ИЙН ЗОХИЦУУЛАГЧ



...../Ч.САРАНЖАВ/

**ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ ТӨСЛИЙН БАЯН-ӨЛГИЙ
АЙМАГ БАЯННУУР СУМЫН НУУР ҮҮСЭХ ТАЛБАЙД БАЙРЛАХ КАЗАХ ИРГЭДИЙН
БУЛШ БУНХАНЫГ НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ АЖЛЫН ГЭРЭЭ**


2024 оны 10 сарын 30 өдөр

Дугаар АЧГ-2024/115

Улаанбаатар хот

Нэг. Гэрээний үндэслэл

Ховд, Увс, Баян-Өлгий аймаг, Эрдэнэбүрэн, Мянгад, Өмнөговь, Баяннуур сумын нутагт байрших Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөлд Монгол Улсын “ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ” хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.11 нөхцөл, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль, Баян-Өлгий аймгийн ЗДТГазрын 2024.09.25-ны өдрийн 8-03/761 тоот “Хамтран ажиллах тухай” албан бичиг, Эрчим хүчний яам ТНБДаргын 2024.10.23-ны өдрийн в/3330 тоот албан бичиг, Эрчим хүчний яамнаас өгсөн чиглэлийг үндэслэн нэг талаас “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл” ТХН (цаашид Захиалагч гэх), нөгөө талаас “Кенжедара трейд” ХХК (цаашид Гүйцэтгэгч гэх) хооронд Захиалагчийн хүсэлтийн дагуу Баян-Өлгий аймаг Баяннуур сумын нутаг дахь шинээр үүсэх усан сангийн талбайн 1315-1325 метрийн түвшинд байрлах казах иргэдийн 60 булш бунханыг нүүлгэн шилжүүлэх ажлыг хийж гүйцэтгэхээр энэхүү гэрээг байгуулав.



Гэрээлэгч талууд:

Захиалагч: Нэр: “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл” ТХН
Хаяг: УБ хот, ХУД, 19-р хороо, Богд Жавзандамба хутагтын гудамж,
“Тайж оффис” групп, 201
Утас: 77551516
Цахим шуудан: info@erdeneburenhpp.mn
Регистрийн дугаар: 9922431

Гүйцэтгэгч: Нэр: “Кенжедара трейд” ХХК
Хаяг: Баян-Өлгий, Толбо, 5-р баг, Хөх толгой, хөх толгой
Утас: 90868777
Цахим шуудан: khadyrkhanat@gmail.com
Регистрийн дугаар: 6395007



Хоёр. Гэрээний ерөнхий зүйл

- 2.1. Ажлын зорилго: Улсын тусгай хэрэгцээний 28000 га талбай тэр дундаа Баян-Өлгий Баяннуур сумын нутаг дахь шинээр үүсэх усан сангийн талбайн 1315-1325 метрийн түвшинд байрлах казах иргэдийн 60 булш бунханыг нүүлгэн шилжүүлэх ажил нь Монгол Улсын болон олон улсын стандарт норм, арга зүйн шаардлагыг хангана.
- 2.2. Ажлын тайлангийн агуулга нь “Баян-Өлгий Баяннуур суманд байрлах казах иргэдийн булш бунханыг нүүлгэн шилжүүлэх” ажлын даалгаварт тусгасан мэдээллүүдийг агуулсан байна.

- 7.3. Гэрээг 3 хувь үйлдэж, хувь тус бүрийг хоёр тал хадгалах ба хуулийн өмнө адил хүчин төгөлдөр байна. Гэрээний хавсралтуудыг мөн адил албажуулна.

Гэрээ байгуулсан:

Гүйцэтгэгч талыг төлөөлж:

“Кенжедара трейд” ХХК-ны Үйл ажиллагаа
хариуцсан менежер С.Есенкелди



С.Есенкелди

Захиалагч талыг төлөөлж:

“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц
төсөл”-ийн Ерөнхий инженер
Ж.Лувсандандар

Ж.Лувсандандар





**БАЙГАЛЬ ОРЧНЫ МОНИТОРИНГ СУДАЛГАА
ХИЙХ АЖЛЫН ГЭРЭЭ**

2024 оны 09 сарын 03 өдөр

Дугаар АЧ-2024/110

Улаанбаатар хот

Нэг. Гэрээний үндэслэл

Ховд, Увс, Баян-Өлгий аймаг, Эрдэнбүрэн, Мянгад, Өмнөговь, Баяннуур сумын нутагт байрших "Эрдэнбүрэнгийн усан цахилгаан станц" төсөлд Монгол Улсын "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулийг баримтлан нэг талаас "Эрдэнбүрэнгийн усан цахилгаан станц" ТХН (цаашид Захиалагч гэх), нөгөө талаас "Тэкол" ХХК (цаашид Гүйцэтгэгч гэх) хооронд Захиалагчийн хүсэлтийн дагуу байгаль орчны мониторинг судалгааг хийхээр энэхүү гэрээг байгуулав.

Гэрээлэгч талууд:

Захиалагч: Нэр: Эрдэнбүрэнгийн усан цахилгаан станц
Хаяг: УБ хот, Хан-Уул дүүрэг, 19-р хороо, Богд Жавзандамба хутагтын гудамж, "Тайж групп" оффис, 201 тоот
Утас: 77551516
Цахим шуудан: info@erdeneburenhpp.mn
Регистрийн дугаар: 9922431

Гүйцэтгэгч: "Тэкол" ХХК
УБ хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Төмөрчний гудамж, 22 байр 19 тоот
Регистрийн дугаар: 2618338
Утас: 99787176
Цахим шуудан: tecol.llc@gmail.com

Хоёр. Гэрээний ерөнхий зүйл

- 2.1. Байгаль орчны мониторинг судалгааны ажлын хүрээнд хийгдэх судалгаа шинжилгээний дүгнэлт, лабораторийн шинжилгээ зэрэг нь Монгол Улсын болон олон улсын стандарт норм, арга зүйн шаардлагыг хангана.
- 2.2. Судалгааны ажлын тайлан нь эх хэл дээр хийгдэнэ. Тухайн ажлын тайланг гадаад хэл рүү хөрвүүлэх бол орчуулгын хөлсийг хоёр тал нэмж харилцан тохиролцоно.
- 2.3. Энэхүү гэрээ нь Гүйцэтгэгч болон Захиалагч талууд хамтран баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 2.4. Гүйцэтгэгч, Захиалагч талуудын хооронд солилцсон материал нь гуравдагч этгээдэд нууц байна.
- 2.5. Захиалагч нь гэрээнд дурдсан төлбөрийг бүрэн барагдуулсны дараа судалгааны ажлын тайланг эзэмших эрх эдэлнэ.
- 2.6. Гэрээт ажлын нийт үнэ: 19 750 000 ₮ (арван ес сая долоон зуун тавин мянган төгрөг) байна.

Гурав. Ажлын гүйцэтгэлийн тухай

- 6.6. Төрийн захиргааны эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу захиалгат ажлыг гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд ажил гүйцэтгээгүйн хариуцлагыг Гүйцэтгэгч тал хариуцахгүй бөгөөд хийсэн ажлын хөлсийг Захиалагч Гүйцэтгэгчид төлнө.

Долоо. Бусад зүйл

- 7.1. Хүндэтгэн үзэх шалтгаан, нөхцөлийн улмаас хоёр тал гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлж амжаагүй бол харилцан тохиролцож хугацааг сунгаж болно.
- 7.2. Харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 7.3. Гэрээг 2 хувь үйлдэж, хувь тус бүрийг хоёр тал хадгалах ба хуулийн өмнө адил хүчин төгөлдөр байна.

Гэрээ байгуулсан:

Гүйцэтгэгч талыг төлөөлж:

“Тэкол” ХХК-ний Зөвлөх мэргэжилтэн

 /Г.Төмөртулга/

Захиалагч талыг төлөөлж:


“Эрдэнбүрэнгийн усан цахилгаан станц”
төсөл Ерөнхий инженер

 /Ж.Лувсандандар/

БАТЛАВ:
“ХОС НАХИА” ХХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ



БАТЛАВ:
“ЭРДЭНЭБҮРЭНГИЙН
ЦАХИЛГААН СТАНЦ ТӨСӨЛ”-ИЙН
ЗОХИЦУУЛАГЧ



**ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ ТӨСЛИЙН ТАЛБАЙН ХӨРСНИЙ
МИКРОБИОЛОГИЙН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ
ХИЙХ АЖЛЫН ГЭРЭЭ**

2024 оны 10 сарын 10 өдөр

Дугаар АЧГ-2024/112

Улаанбаатар хот

Нэг. Гэрээний үндэслэл

Ховд, Увс, Баян-Өлгий аймаг, Эрдэнэбүрэн, Мянгад, Өмнөговь, Баяннуур сумын нутагт байрших Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөлд Монгол Улсын "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулийг баримтлан нэг талаас “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл” ТХН (цаашид Захиалагч гэх), нөгөө талаас “Хос нахиа” ХХК (цаашид Гүйцэтгэгч гэх) хооронд Захиалагчийн хүсэлтийн дагуу төслийн талбай дахь хөрсний микробиологийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэхээр энэхүү гэрээг байгуулав.

Гэрээлэгч талууд:

Захиалагч: Нэр: “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл” ТХН
Хаяг: УБ хот, ХУД, 19-р хороо, Богд Жавзандамба хутагтын гудамж,
“Тайж оффис” групп, 201
Утас: 77551516
Цахим шуудан: info@erdeneburenhpp.mn
Регистрийн дугаар: 9922431

Гүйцэтгэгч: Нэр: “Хос нахиа” ХХК
Хаяг: УБ хот, ЧД, 5-р хороо, MN tower, 12 давхар, 1201 тоот
Утас: 93393035, 90963535
Цахим шуудан: khosnakhiallc@gmail.com
Регистрийн дугаар: 6407447


Хоёр. Гэрээний ерөнхий зүйл

- 2.1. Ажлын зорилго: Төслийн нөлөөлөлд өртөж буй Увс аймгийн Өмнөговь сумын 125 айл өрх, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын 145 айл өрхийн нүүлгэн шилжүүлэлтээс үүсэх хөрсний гадаргын микробиологийн бохирдлын түвшин усан сан үүсгэн усыг хуримтлуулахад сөрөг нөлөө үзүүлэх эсэхийг тодорхойлох судалгааны ажлын тайлан нь Монгол Улсын болон олон улсын стандарт норм, арга зүйн шаардлагыг хангана.
- 2.2. Судалгааны ажлын тайлан нь эх хэл дээр хийгдэнэ. Тухайн ажлын тайланг гадаад хэл рүү хөрвүүлэх бол орчуулгын хөлсийг хоёр тал нэмж харилцан тохиролцоно.
- 2.3. Энэхүү гэрээ нь Гүйцэтгэгч болон Захиалагч талууд хамтран баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 2.4. Гүйцэтгэгч, Захиалагч талуудын хооронд солилцсон материал нь гуравдагч этгээдэд нууц байна.
- 2.5. Захиалагч нь гэрээнд дурдсан төлбөрийг бүрэн барагдуулсны дараа судалгааны ажлын тайланг эзэмших эрх эдэлнэ.
- 2.6. Гэрээт ажлын нийт үнэ: 46,740,000 ₮ (дөчин зургаан сая долоон зуун дөчин мянган төгрөг) байна.

Гэрээ байгуулсан:

Гүйцэтгэгч талыг төлөөлж:

“Хос нахиа” ХХК-ний Ерөнхий менежер
Э.Баасансүх



.....

Захиалагч талыг төлөөлж:

“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц
төсөл”-ийн Ерөнхий инженер
Ж.Лувсандандар



.....